

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Ангилалтын код 13.100

Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын менежмент– COVID-19 цар тахлын үед аюулгүй ажиллах ерөнхий зааварчилгаа	MNS ISO/PAS 45005:2021
Occupational health and safety management — General guidelines for safe working during the COVID-19 pandemic	ISO/PAS 45005:2020

Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2021 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн С/01 дугаар тушаалаар батлав.

Энэхүү стандарт нь 2021 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1 Хамрах хүрээ

Энэхүү баримт бичиг нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг хамгаалах зорилгоор байгууллагад COVID-19-тэй холбоотой эрсдэлийг удирдах ерөнхий зааварчилгаа юм. Энэхүү баримт бичиг нь хэмжээ, үйл ажиллагааны салбараас үл хамааран дараах байгууллагад хэрэглэх боломжтой. Үүнд:

- а) цар тахлын үеэр үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байгаа;
- б) бүрэн буюу хэсэгчлэн хаасны дараа үйл ажиллагаагаа сэргээж байгаа эсвэл сэргээхээр төлөвлөж байгаа;
- с) бүрэн буюу хэсэгчлэн хаагдсан ажлын байрандаа эргэн орж байгаа;
- д) үйл ажиллагаагаа шинээр эхэлж байгаа эсвэл шинээр эхлэхээр төлөвлөж байгаа.

Энэхүү баримт бичиг нь бүх төрлийн ажилтан (жишээлбэл, байгууллагын ажилтан, гаднаас үйлчилгээ үзүүлж буй ажилтан, гэрээт гүйцэтгэгч, хувиараа бизнес эрхлэгч, агентлагийн ажилтан, ахмад ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, анхны тусламжийн ажилтан) болон бусад холбогдох сонирхогч талууд (жишээлбэл, ажлын байран дээрх зочин, түүний дотор олон нийтийн байгууллагын гишүүд)-ыг хамгаалах талаар зааварчилгаа өгнө.

Энэхүү баримт бичиг нь халдварын хяналтын тусгай протоколыг эмнэлзүйн, эрүүл мэндийн болон бусад орчинд хэрхэн хэрэгжүүлэх талаар зааварчилгаа өгөхөд зориулагдаагүй болно.

ТАЙЛБАР: Эдгээр нөхцөлд эсвэл зохих албан тушаалд байгаа ажилтанд зориулсан холбогдох хууль тогтоомж, удирдамжийг засгийн газар, зохицуулалт, эрүүл мэндийн байгууллагууд өгнө.

2 Норматив эшлэл

Энэ баримт бичигт эшлэл болгон авсан баримт бичиг байхгүй байна.

3 Нэр томъёо, тодорхойлолт

Энэ баримт бичигт дараах нэр томъёо, тодорхойлолтыг хэрэглэнэ. Үүнд:

ОУСБ ба ОУЦТК-ын дараах хаягаар стандартчиллын нэр томъёоны мэдээллийн санд нэвтэрч болно. Үүнд:

- ОУСБ-ын цахим платформ: www.iso.org/obp
- ОУЦТК-ын электропедиа: <http://www.electropedia.org/>

3.1

MNS ISO/PAS 45005 : 2021

байгууллага

зорилгодоо хүрэх үүрэг хариуцлага, эрх мэдэл, харилцаатай, өөрийн гэсэн чиг үүрэг бүхий хүн эсвэл хэсэг бүлэг хүмүүс

Нэмэлт тайлбар 1: Байгууллага гэдэг ойлголтод хуулийн этгээдийн бүртгэлд байгаа эсэхээс үл хамааран төрийн эсвэл хувийн хэвшлийн компани, корпораци, фирм, аж ахуйн нэгж, захиргааны байгууллага, нөхөрлөл, нийгэмлэг (3.2.8), буяны байгууллага эсвэл хүрээлэн, онцгой эрхтэй худалдаачин эсвэл тэдгээрийн хэсэг нэгж буюу нэгдэл хамаарах ба эдгээрээр хязгаарлагдахгүй.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 45001:2018, 3.1-р заалтыг өөрчилсөн - Нэмэлт тайлбар 1-ээс "холбоо" гэсэн үгийг хассан ба Нэмэлт тайлбар 2-ийг шаардлагагүй гэж үзсэн.]

3.2

ажилтан

байгууллагын (3.1) хяналт дор явагддаг ажил эсвэл энэ ажилтай хамааралтай үйл ажиллагааг гүйцэтгэж буй хүн

Нэмэлт тайлбар 1: Ажил эсвэл энэ ажилтай холбоотой үйл ажиллагааг цалинтай эсвэл цалингүй, тогтмол эсвэл түр хугацаагаар, завсарлагатайгаар эсвэл улирлаар, ердийн эсвэл хагас цагаар зэрэг төрөл бүрийн тохиролцооны үндсэн дээр гүйцэтгэнэ.

Нэмэлт тайлбар 2: Дээд удирдлага (3.12), удирдлагын болон удирдлагын бус түвшний бүх хүмүүсийг ажилтан гэнэ.

Нэмэлт тайлбар 3: Байгууллагын хяналт дор явагддаг ажил эсвэл ажилтай холбоотой үйл ажиллагааг байгууллагын өөрийн ажилтан, эсвэл гаднаас үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтан, гэрээт ажилтан, хувь хүмүүс болон агентлагийн ажилтан байгууллагын төлөв байдлын дагуу байгууллагаас тавьж буй хяналтын хүрээнд гүйцэтгэж болно.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 45001:2018, 3.3]

3.3

ажлын байр

хүн байх шаардлагатай эсвэл ажил хийхээр очих шаардлагатай байгууллагын (3.1) хяналтад байдаг газар

Нэмэлт тайлбар 1: Байгууллагын ажлын байртай холбоотой үүрэг хариуцлага нь ажлын байранд тавих хяналтын түвшингээс хамаарна.

Нэмэлт тайлбар 2: Ажилтны өөрийн гэр (3.2), бусдын гэр, хувийн автомашин, байгууллагын тээврийн хэрэгсэл, бусад байгууллагын байр, олон нийтийн газруудыг ажлын байр гэж үзэж болно.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 45001:2018, 3.6 заалтыг өөрчилсөн –Нэмэлт тайлбар 1-ээс "ХАБЭА-н менежментийн тогтолцооны хүрээнд" гэснийг хасаж, Нэмэлт тайлбар 2-ийг нэмсэн.]

3.4

эрсдэл

тодорхой бус байдлын үр нөлөө

Нэмэлт тайлбар 1: Энэхүү баримт бичигт өөрөөр заагаагүй бол "эрсдэл" гэсэн нэр томъёо нь COVID-19 (3.6)-д холбоотой эрсдэлийг хэлнэ.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 45001:2018, 3.20 заалтыг өөрчилсөн - анхны Нэмэлт тайлбаруудыг хасаж, Нэмэлт тайлбар 1-ийг шинээр нэмж оруулав.]

3.5

цар тахал

өвчин дэлхийн хэмжээнд тархах үзэгдэл

[ЭХ СУРВАЛЖ: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага [9], өөрчлөгдсөн - "шинэ" гэсэн үгийг хассан.]

3.6

COVID-19

2019 онд илрүүлсэн SARS-CoV-2 шинэ төрлийн коронавирусууд эсвэл үүдэлтэй халдварт өвчин

[ЭХ СУРВАЛЖ: Дэлхийн эрүүл мэндийн байгууллага [10] өөрчлөн “2019 онд илрүүлсэн SARS-CoV-2” гэсэн үг нэмж оруулав.]

3.7

аюултай тохиолдол

ажлаас эсвэл уг ажлыг гүйцэтгэж байх явцад гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохиролд хүргэж болох эсвэл хүргэсэн тохиолдол

Нэмэлт тайлбар 1: Энэхүү баримт бичигт "гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохирол" гэдэг нь COVID-19 (3.6) вирусээр шууд халдварлах, эсвэл COVID-19-ээс үүдэлтэй бие махбодын болон сэтгэцийн гэмтэл ба/эсвэл эрүүл мэндийн хохиролд хамаарна.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 45001:2018, 3.35, өөрчлөгдсөн - анхны Нэмэлт тайлбаруудыг хассан ба Нэмэлт тайлбар 1-ийг шинээр нэмж оруулав.]

3.8

хувийн хамгаалах хэрэгсэл XXX

эрүүл мэнд, аюулгүй байдалд заналхийлж буй нэг буюу хэд хэдэн аюулаас хамгаалах зорилгоор хүн хэрэглэх зориулалттай төхөөрөмж эсвэл хэрэгсэл

Нэмэлт тайлбар 1: XXX нь халаад, бээлий, амьсгалын аппарат, нүд хамгаалах шил, малгай, хамгаалалтын шил зэргийг багтаадаг ба эдгээрээр хязгаарлагдахгүй.

Нэмэлт тайлбар 2: Ерөнхийдөө маскийг XXX гэж үздэггүй ч [болон нүүрний хаалт (3.9)] энэ нь халдвар дамжуулах, тархах үйл явцыг хянах нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээ болох үндсэн зорилгоос гадна хэрэглэж байгаа хүнд тодорхой түвшний хамгаалалтыг бий болгож чаддаг.

Нэмэлт тайлбар 3: Олон оронд XXX-ийн үндэсний дүрэм журмыг дагаж мөрдөх шаардлага тавьдаг.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 15384:2018, 3.12 заалтыг өөрчилсөн - тодорхойлолтоос “эсвэл барих” гэсэн үгсийг хасаж Нэмэлт тайлбаруудыг нэмж оруулсан.]

3.9

нүүрний хаалт

ам, хамар, эрүүг бүрхсэн хошуувч

Нэмэлт тайлбар 1: Нүүрний хаалтыг нийтээр хэрэглэх маск, эрүүл ахуйн хэрэгцээний маск, хаалт, тав тухын гэх зэргээр тухайн улсад хэвшсэн нэрээр нэрлэдэг.

Нэмэлт тайлбар 2: Энэ баримт бичигт нүүрний хаалтыг эмнэлгийн хэрэгсэл эсвэл хувийн хамгаалах хэрэгсэл (3.8) гэж үзэхгүй.

[ЭХ СУРВАЛЖ: CWA 17553:2020, 2.3 заалт өөрчлөгдсөн - "нийтийн" гэсэн үгийг нэр томъёоноос хассан,"толгой ба чихний бэхэлгээ бүхий тоноглолтой байх" гэсэн үгийг тодорхойлолтоос хасаж Нэмэлт тайлбар 1-ийг шинээр нэмж оруулсан.]

3.10

сайн сайхан байдал

ажилтны (3.2) ажил үүрэгтэй холбоотой бие бялдар, оюун ухаан, танин мэдэхүйн хэрэгцээ, хүлээлтийг хангасан байдал

Нэмэлт тайлбар 1: Сайн сайхан байдал нь ажлын бус үеийн амьдралын чанарт нөлөөлнө.

Нэмэлт тайлбар 2: Сайн сайхан байдал гэдэг нь хөдөлмөрийн зохион байгуулалт, ажлын байран дахь нийгмийн хүчин зүйлс, ажлын орчин, тоног төхөөрөмж, аюултай ажил зэрэг бүхий л асуудалтай холбоотой.

[ЭХ СУРВАЛЖ: ISO 45003:¹), 3.2 заалтыг өөрчилсөн - "Ажлын байран дээр" гэсэн үгийг нэр томъёо болон Нэмэлт тайлбараас хассан.]

3.11

нийтийн эзэмшлийн газар

нэгээс дээш хүний ашиглах зориулалттай байр, байгууламж

¹ ISO/DIS 45003:2020 хэвлэлтийн үе шатанд байгаа. ЭХ СУРВАЛЖ: ISO 45003:2020, 3.2 заалтыг өөрчилсөн - "Ажлын байран дээр" гэсэн үгийг нэр томъёо болон Нэмэлт тайлбараас хассан.]

MNS ISO/PAS 45005 : 2021

Жишээ: Хоолны газар, цахилгаан шат/урсдаг шат, хүлээн авах хэсэг, хурлын өрөө, мөргөлийн өрөө, сүм дуган, бие засах газар, цэцэрлэг, галын гарц, гал тогоо, бялдаржуулах төв, хадгалах өрөө, угаалгын газар.

4 Төлөвлөлт ба эрсдэлийн үнэлгээ

4.1 Байгууллагын төлөв байдлыг ойлгох нь

4.1.1 Байгууллагын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөж болзошгүй ажилтан ба бусад хүмүүс (зочид, хэрэглэгч, үйлчлүүлэгч, олон нийт)-т учрах тодорхой эрсдэлийг ойлгохын тулд байгууллага дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- a) COVID-19 цар тахлын үед хүмүүсийн аюулгүй ажиллах чадавхад юу нөлөөлж болох;
- b) хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд үзүүлэх өсөн нэмэгдэж буй эрсдэлд чиглүүлэн үйл ажиллагаагаа хэрхэн өөрчлөх.

COVID-19 цар тахалтай холбоотой эрсдэлийг үнэлэхээс өмнө байгууллага нь ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болох гадаад ба дотоод онцлог асуудал болон цар тахлын нөлөөгөөр эдгээр асуудалд ямар өөрчлөлт гарсныг тус тус авч үзнэ. Байгууллага нь үйл ажиллагаагаа эхлүүлэх, үргэлжлүүлэх, өөрчлөх үед хийх эрсдэлийн үнэлгээ ба төлөвлөлтөд эдгээр гадаад ба дотоод асуудлыг авч үзэх ба эрсдэлийг тогтмол үнэлж байх шаардлагатай.

4.1.2 Гадаад асуудалд дараах асуудлыг авч үзэж болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- a) иргэдийн дунд COVID-19 тархсан байдал (бусад байгууллага болон ажлын байрыг хамруулна);
- b) орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын нөхцөл байдал ба холбогдох хууль тогтоомжийн шаардлага болон зааварчилгаа;
- c) эрүүл мэндийн үйлчилгээ, оношилгоо, эмчилгээ, вакцины хүртээмж;
- d) эрүүл мэнд, аюулгүй байдлын болон бусад ханган нийлүүлэлтийн хүртээмж (XXX, маск, гар ариутгагч, халуун хэмжигч, цэвэрлэгээний болон ариутгалын материал);
- e) ажилтан ажил ба гэр хоорондоо хэрхэн явах (нийтийн тээвэр, машин, унадаг дугуй, явган алхах);
- f) ажилтан хүүхдээ асрах, сургуульд сургах боломж;
- g) ажилтан зайнаас ажиллахад гэртээ тохиромжтой эсэх;
- h) ажилтны амьдралын нөхцөл байдал (өөрөөр хэлбэл, COVID-19халдвар авах өндөр эрсдэлтэй, эсвэл COVID-19халдвартай, хүнд өвчтөнтэй хамт амьдарч байгаа эсэх);
- i) ханган нийлүүлэлтийн сүлжээнд гарч буй өөрчлөлт эсвэл асуудал;
- j) үндсэн үйлчилгээний тасралтгүй байдал (хүнсний хангалт, дэд бүтэц, цахилгаан, дулаан, ус);
- k) хэрэглэгчийн хэрэгцээ ба хүлээлт, зан байдалд гарч буй өөрчлөлт;
- l) орон нутгийн соёл ба соёлын зан үйл (үнсэх, тэврэх, гар барих);
- m) бүтээгдэхүүн/үйлчилгээний эрэлт ихсэх эсвэл багасах хандлага.

4.1.3 Дотоод асуудалд дараах асуудлыг авч үзэж болох ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

- a) байгууллага дотор COVID-19халдвар илэрсэн эсэх;
- b) ажлын байрны тоо ба төрөл (оффис, үйлдвэр, цех, агуулах, авто тээврийн хэрэгсэл, жижиглэн худалдааны газар, ажилтны өөрийн гэр, бусдын гэр);
- c) эрсдэлийг хянах арга хэмжээнд нөлөөлж болохуйц байгууллагын соёлын үнэт зүйл;

- d) байгууллагын COVID-19-ийн талаар хамгийн сүүлийн үеийн мэдлэг авах чадвар;
- e) байгууллагын төрөл ба үйл ажиллагаа (үйлдвэрлэл, үйлчилгээ, жижиглэн худалдаа, нийгмийн халамж, сургалт ба бусад боловсрол, хүргэлт, түгээлт);
- f) байгууллага доторх ажилтны төрөл (үндсэн, гэрээт, сайн дурын, чөлөөт, хагас цагийн, ээлжийн, зайны ажилтан);
- g) хүн хоорондын зай барих арга хэмжээг хэрэгжүүлэх боломж;
- h) ажилтны тусгай хэрэгцээ (COVID-19-ийн хавьталд орох өндөр эрсдэлтэй эсвэл хүнд өвдөх магадлалтай ажилтан);
- i) халамжийн ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, жирэмсэн эмэгтэйчүүд, нярай хүүхэдтэй ээж, ахмад настай ажилтан;
- j) ажилдаа ирэхгүй ажилтны тоо нэмэгдсэн байдал (өвчтэй, өөрийгөө тусгаарлах эсвэл хөл хорионы шаардлага, гэр бүлд нь гарз хохирол учрах зэрэг шалтгаанаар);
- k) ариун цэврийн өрөө ба гар угаах байгууламжийн хангамж гэх мэт нөөцийн хүртээмж;
- l) ажлаа хэрхэн зохион байгуулж (ажлын шаардлага, ажлын хурд, цаг хугацааны дарамт, ээлжийн ажилд орсон өөрчлөлт) дэмжиж, энэ нь хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд хэрхэн нөлөөлж байгаа байдал.

4.2 Манлайлал ба ажилтны оролцоо

4.2.1 COVID-19 цар тахалтай холбоотой эрсдэлийг үр дүнтэй удирдахын тулд байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

a) манлайлал ба тууштай байдлаа хамтын хариуцлага, аюулгүй ажиллагааны дадлаар харуулах;

b) дотоод бодлогыг тогтмол мэдээлэх, нийцүүлж ажиллах;

Тайлбар: Орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний зааварчилгааг мөрдөж болно.

c) COVID-19-ийн сэжигтэй болон батлагдсан тохиолдлыг тайлагнах, удирдахдаа ил тод байх зарчмыг баримтлах, гэхдээ хувь хүний эрүүл мэндийн мэдээллийн нууцлалыг хадгалах (5-р бүлгийг үзнэ үү);

d) шаардлагатай нөөцөөр хангах (8-р бүлгийг үзнэ үү), түүнийг ажилтанд цаг тухайд нь, үр дүнтэй байдлаар хүргэх;

e) ажилтан, байгаа бол ажилтны төлөөллийг хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлын талаарх шийдвэр гаргахад оролцуулах, зөвлөлдөх үйл явцыг дэмжих;

f) үйл ажиллагааны хязгаарлалтаас ажиллах боломжгүй болсон эсвэл өөрийгөө тусгаарлах эсвэл хөл хорионы дэглэм барих шаардлагатай болсон ажилтны санхүүгийн нөлөөллийн талаар тодорхой бодлого боловсруулах;

g) үйл ажиллагааны хязгаарлалтаас ажиллах боломжгүй эсвэл өөрийгөө тусгаарлах эсвэл хөл хорионы дэглэм барих шаардлагатай болсон ажилтанд амралт, боломжтой бол өвчний цалинтай чөлөө олгох (ингэснээр өвчтэй байж болзошгүй ажилтан цалингүй болохоос айж ажилдаа ирэхээс сэргийлэх) зэрэг зохих дэмжлэг үзүүлэх;

h) ажилтан болон сонирхогч талууд аюултай тохиолдлыг мэдэгдэх эсвэл асуудал дэвшүүлэхдээ хэрхэн харилцах, эдгээрийг хэрхэн шийдвэрлэх, хариуг хэрхэн хүргэх;

i) ажилтан болзошгүй өвчин, ослын талаар мэдээлэх, эсвэл ажилтан эрүүл мэндэд хортой, аюултай гэж үзсэн ажлаа орхих тохиолдолд түүнд шийтгэл оногдуулахгүй байх;

j) COVID-19-с үүссэн эрсдэлийг удирдах, эрсдэлийг хянах арга хэмжээг байгууллагын бүхий л хэсэгт зохион байгуулан, хэрэгжүүлэх;

MNS ISO/PAS 45005 : 2021

к) шаардлагатай бол, COVID-19-тэй холбоотой эрсдэлийг удирдахтай холбоотой мэдээлэл ба зөвлөгөөг эрх бүхий байгууллагаас авах.

4.2.2 Байгууллага нь түүний үйл ажиллагааны нөлөөнд өртөж болзошгүй ажилтан ба хэрэглэгч, үйлчлүүлэгч, олон нийт зэрэг бусад сонирхогч талуудад анхаарал тавих үүрэгтэй. Байгууллага нь тэдний оролцоог дэмжиж ажиллах нь цар тахлын үеэр үүсэж болох хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд үзүүлэх эрсдэлийг илүү сайн харах боломжтой болно. Ажилтан ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөлтэй идэвхтэй, байнгын харилцаа холбоотой байж COVID-19-тэй холбоотой эрсдэлийг илүү үр дүнтэй удирдана.

Байгууллага нь дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

а) COVID-19-тэй холбоотой эрсдэлийг үнэлэх, удирдах талаар шийдвэр гаргахдаа ажилтан, хэрэв байгаа бол тэдгээрийн төлөөллийг оролцуулах, оролцоог дэмжих;

б) байгууллага COVID-19-тэй холбоотой эрсдэлийг хэрхэн удирдаж буй талаар ажилтан болон бусад оролцогч талуудад (жишээлбэл, олон нийт, үйлчлүүлэгч, ханган нийлүүлэгч, зочид, оюутан, хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч, зохицуулагч, үйлдвэрчний эвлэл) мэдээлэх (харилцаа холбоог ямар ч тохиромжтой аргаар хийж болно, 9-р зүйлийг үзнэ үү);

в) ажилтан болон бусад оролцогч талуудад хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдлыг удирдах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар нэг буюу хэд хэдэн аргаар санал хүсэлтээ илэрхийлэх боломж олгох (жишээлбэл, виртуал уулзалт, хамтын ажиллагааны бусад хэрэгсэл, онлайн судалгаа, цахим шуудангаар дамжуулан гэх мэт);

д) ажилтан болон бусад оролцогч талуудын дэвшүүлсэн саналыг цаг тухайд нь шийдвэрлэх, зохих арга хэмжээ авах, авсан арга хэмжээний талаар тэдэнд эргэж мэдээлэх.

Байгууллага шийдвэр гаргагч ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөл нь нийт ажиллах хүчний өөр өөр байдал, жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, эмэгтэйчүүд, өөр өөр үндэстэн, шашны бүлгийн ажилтан, янз бүрийн насны ажилтны тодорхой туршлага, үзэл бодол, хэрэгцээ шаардлагыг харгалзан үзэх нөхцөлийг бүрдүүлнэ.

4.3 Ерөнхий төлөвлөлт

4.3.1 Төлөвлөлт нь байгууллагад цар тахлын улмаас хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрэмбэлэх боломж олгоно.

COVID-19-тэй холбоотой эрсдэлийг бүрэн арилгах боломжгүй ч төлөвлөлт нь эдгээр эрсдэлийг бууруулахын тулд ажилтанд үзүүлэх эрсдэлийг тодорхойлж, эрэмбэлэх асуудлыг авч үзнэ.

Байгууллага төлөвлөлтөд 4.1-д тодорхойлсон асуудлын хүрээнд дараах зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

а) ажлаа хэрхэн зохион байгуулах, хаана хийх талаар авч хэрэгжүүлэх шаардлагатай бодитой өөрчлөлт;

б) ажилтан хоорондын харилцаа;

в) ажилтан болон бусад хүмүүс, түүний дотор зочид, үйлчлүүлэгч, олон нийтийн гишүүд хоорондын харилцан үйлчлэл;

д) нууцлалын горимыг мөрдөж, ойрын хавьталд орсон хүнийг (жишээлбэл, ээлжийн ажилтан, паб, рестораны үйлчлүүлэгч, биеийн тамирын заалаар үйлчлүүлэгч) мөшгөх зорилгоор тэдгээртэй холбоо барих бүрэн, үнэн зөв мэдээллийг хэрхэн бий болгох;

е) нийтийн эзэмшлийн газар, дундын тоног төхөөрөмжийг аюулгүй ашиглах;

ж) цар тахлын сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдалд үзүүлэх нөлөө (6-р бүлэг үзнэ үү).

4.3.2 Байгууллага нь COVID-19-тэй холбоотой эрсдэлийг тодорхойлох, шийдвэрлэхэд системтэй хандах ба дараах төрлийн ажлыг тодорхойлсон байх шаардлагатай. Үүнд:

a) гэрээсээ хийх боломжтой ажил;

b) гэрээс хийх боломжгүй ба ажлын байранд бодит өөрчлөлт хийсэн, хүн хоорондын зайн дүрэм мөрдөн гүйцэтгэж болох ажил;

c) гэрээс хийх боломжгүй, мөн ажлын байранд хүн хоорондын зайн дүрэм мөрдөх боломжгүй ажил.

Ихэнх байгууллагын хувьд түүний дотор өвчин тархахаас хамгаалах хяналтын арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн байгууллагад мөн адил COVID-19-ийн эрсдэлийг бууруулах хамгийн сайн арга бол Ажилтныг гэрээр ажиллах боломжийг олгох, дэмжих явдал юм.

Байгууллага нь бусадтай харьцах, хавьтлыг багасгах замаар хамгаалалтыг нэмэгдүүлэх зорилгоор боломжтой бол ажлын байранд биеэр ирж ажиллах ажилтны тоог багасгах шаардлагатай.

Байгууллага нь ажлын байранд ирж ажиллах ажилтны тоог тодорхойлохдоо үйлчилгээ авагч, түнш, хэрэглэгч, түүнчлэн ажил гүйцэтгэж буй ажилтны эрэлт хэрэгцээг харгалзан үзсэн байна.

Байгууллага нь гэрээсээ ажиллаж байгаа ажилтны бие бялдар, сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах талаар нэмэлт дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

Хэрэв зарим нэг ажилтны гэр ажил хийхэд тохиромжгүй, гэрээсээ ажиллах нь тэдний сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд ихээхэн сөрөг нөлөөтэй, ажилтан ажлын байранд аюулгүй ирж,буцах боломжтой бол энэ асуудлыг байгууллага анхаарч үзэх шаардлагатай.

Гэрээс хийх боломжгүй, хүн хоорондын зайн дүрэм мөрдөх боломжгүй ажлыг хэрэв эдгээр ажил нь чухал бөгөөд эрсдэлийг бууруулах нэмэлт хяналтыг авч хэрэгжүүлсэн тохиолдолд зөвхөн гүйцэтгэнэ.

4.3.3 Байгууллага нь COVID-19-тэй холбоотой эрсдэлд чиглэсэн арга хэмжээг төлөвлөхдөө одоо байгаа ХАБЭА-н эрсдэл ба эрсдэлийг удирдах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээг авч үзсэн байна.

Байгууллага дараах арга хэмжээ авна. Үүнд:

a) ажлын дараалалд гарсан аливаа өөрчлөлтийг харгалзан үзсэний үндсэн дээр одоо байгаа ХАБЭА-н арга хэмжээ, хяналтыг тохируулах хэрэгцээг үнэлэх;

b) COVID-19-тэй холбоотой эрсдэл (Хамгаалалтын аюулгүй байдлын талаар А хавсралтыг үзнэ үү)-ийг удирдах аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээний хамт хэрэгжүүлэх ХАБЭА-н шинэ эрсдэл (жишээлбэл, галын аюулгүй байдлын арга хэмжээнд үзүүлэх нөлөө) болон бусад эрсдэлийг (жишээлбэл, хамгаалалттай холбоотой эрсдэл) харгалзан үзэх;

c) шинэ эрсдэлд чиглэсэн арга хэмжээг төлөвлөх;

d) үйл ажиллагааны тасалдлыг хамгийн бага байлгах (4.8-г үзнэ үү) зорилгоор орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын түвшинд хязгаарлалтын өөрчлөлтийг богино хугацаанд төлөвлөх.

4.4 Ажлын байр

4.4.1 Биеэр очиж ажиллах ажлын байр

4.4.1.1 Байгууллага нь ажлын байр (ажил явагдаж буй бүх байр, сайт, бусад газрууд,түүнчлэн барилгын гадна талд) болон эдгээр ажлын байрны доторх байгууламжийн ашиглалтын аюулгүй, цэвэр байдлыг хангана.

Үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах зорилгоор байгууллага хамгийн багадаа дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:

MNS ISO/PAS 45005 : 2021

а) бүх байр, байршил, байршлын хэсэг, түүнчлэн хаалттай буюу хэсэгчлэн ажиллаж байсан хэсгийг үнэлэх;

б) халдвартай байж болзошгүй хүмүүсийг ажлын байранд нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах(жишээлбэл, COVID-19-ийн шинж тэмдэгтэй хүн ажлын байранд нэвтрэхгүй байх талаар ажилд ирэхийн өмнө мэдээлэх эсвэл зарлах);

с) тоног төхөөрөмж, системийн засвар үйлчилгээ, ашиглалтын шалгалт хийх;

д) эрүүл мэндийн бусад эрсдэлээс сэргийлэх зорилгоор, ялангуяа усан суурьтай системийг тодорхой хугацаанд ашиглаагүй эсвэл хэрэглээ нь багассан бол (зарим төрлийн агааржуулагч) легионелла болон бусад усаар дамжих өвчний эрсдэлийг үнэлж, хянах;

е) цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг өргөн хүрээнд хамруулах ба давтамжийг нэмэгдүүлсэн хуваарь тогтоох (жишээлбэл, цэвэрлэгээ хийх ажлын цаг болон/эсвэл цэвэрлэгээ хийдэг ажилтны тоог нэмэгдүүлэх, бусад Ажилтныг өөрсдийн ажлын талбай, тоног төхөөрөмжийг тогтмол цэвэрлэж, ариутгахыг уриалах);

ф) боломжтой бол гар угаах нэмэлт төхөөрөмж суурилуулах, боломжгүй бол гар ариутгах цэг бий болгох (ажил, завсарлагаанд ашигладаг гадаа талбай орно) зэргээр хувийн ариун цэврийн бүтээгдэхүүний хүртээмжийг сайжруулах, эдгээр нь хөгжлийн бэрхшээлтэй ажилтанд хүртээмжтэй байхад анхаарах;

г) байршил хуваалцаж буй гэрээт гүйцэтгэгчид, менежментийн агентууд, газрын эзэн болон бусад түрээслэгчид зэрэг бусад байгууллагуудтай хамтарч ажиллах, ердийн үйл ажиллагаа болон онцгой байдлын төлөвлөгөөг харгалзан үзсэн байх

4.4.1.2 Байгууллага нь цаашид дараах арга хэмжээг авах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

а) ажлын байр, тоног төхөөрөмжийг гүн цэвэрлэх, ариутгах;

б) цорго, шүршүүр болон бусад усны эх үүсвэрийг COVID-19-ийн эсрэг хэрэглэх албан ёсны шаардлага хангасан бүтээгдэхүүнээр ариутгах, хэрэглэхээс өмнө зайлах;

с) агааржуулалтын системээр (зохих шүүлтүүр, ашиглалтын хугацаатай) гаднах агаар, өрөөний агаарын өөрчлөлтийг хамгийн их байлгах, агаарын эргэлтийн системийг унтрааж, хаалга, цонхыг аль болох нээлттэй байлгах;

д) ариун цэврийн өрөөг аюулгүй ашиглах зорилгоор зохих хяналтыг хэрэгжүүлэх (12.6.2-ыг үзнэ үү);

е) ердийнхөөс удаан ашиглаагүй тусгай тоног төхөөрөмжийг дахин ажиллуулах, шалгах;

ф) галын аюулгүй байдлын систем, түүнчлэн яаралтай тусламжийн гэрэлтүүлэг, дохиолол гэх мэт батерейгаар ажилладаг төхөөрөмжүүдийг турших;

г) санал болгосон хүн хоорондын зайг харуулахын тулд шал эсвэл ханан дээр тэмдэг, тэмдэглэгээг суурилуулах, харааны бэрхшээлтэй хүмүүст харагдахуйц, энгийн, ойлгомжтой, том хэмжээтэй байх;

h) ХАБЭА-н шинэ эрсдэл, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст бусад эрсдэл, сөрөг нөлөөлөл үүсэхгүй байдлаар хүн хоорондын зай барихад шаардлагатай физик саадыг боломжийн хирээр, аюулгүй байрлуулах;

и) аль нэг хэсэгт (12.5-ыг үзнэ үү) хүний тоог хязгаарлах ажлын талбай бий болгох;

j) дундаа тоног төхөөрөмж ашиглах тохиолдолд тухайн төхөөрөмж дээр ажиллах ажлын хэсэг эсвэл хосыг томилох замаар хүмүүсийн тоог хязгаарлах;

к) ажлын цагаар ажилтан гадаргуу, тоног төхөөрөмжийг арчиж цэвэрлэх боломжтой цэвэрлэх, ариутгалын цэгийг бий болгох;

- l) хөдөлгөөнт төхөөрөмж, ширээ, ажлын байрыг өөрчлөн зохион байгуулж, хүн хоорондын зайг хангах;
- m) хаалганы бариулд хүрэхийг багасгах зорилгоор хаалгыг аль болох нээлттэй байлгах (галын аюулгүй байдал, хамгаалалт, нууцад шаардагдах хаалгануудаас бусад);
- n) ажлын байрнаас аюулгүй нэвтрэх, гарах үйл явцыг бий болгох;
- o) коридор, шатны хонгил болон бусад нийтийн газруудад нэг чигийн хөдөлгөөний тэмдэг, тэмдэглэгээг шал, ханан дээр суурилуулах, боломжгүй тохиолдолд эрсдэлийг бууруулах бусад арга хэмжээ авах;
- p) цахилгаан шат/урсдаг шат ашиглах аюулгүй арга хэлбэр, түүний дотор багтаамжийн хязгаарлалтыг тодорхойлох, цахилгаан шат/урсдаг шатны дотор болон гадна талд аюулгүй ашиглах зааврыг байрлуулахад анхаарах;
- q) ажилтны ердийн ажил, уулзалт, боломжтой бол завсарлагаанд зориулж гадаа нэмэлт зай гаргаж өгөх.

4.4.2 Гэрээсээ ажил хийх

4.4.2.1 Цар тахлын эрсдэлийг удирдах хамгийн үр дүнтэй аргуудын нэг тул байгууллага нь Ажилтныг боломжтой бол гэрээсээ ажил хийх боломжоор хангах шаардлагатай. Байгууллага нь гэрээсээ ажилдаг ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдлын талаар ажлын байранд ирж ажиллаж байгаа ажилтанд тавьдагтай адил хариуцлага хүлээдэг. Байгууллага нь гэрээсээ ажил хийхэд тулгардаг саадыг арилгах бүх практик арга хэмжээг авсан байх шаардлагатай.

Байгууллага нь хэнийг гэрээсээ ажил хийж болохыг тодорхойлохдоо ажилтнуудаас дараах асуулт асууна. Үүнд:

- a) Та гэртээ ажлаа үр дүнтэй гүйцэтгэх боломжтой юу?
- b) Танай гэрийн нөхцөл байдал ажил хийхэд тохиромжтой юу?
- в) Та ажлын байранд ирж ажиллахыг хүсэж байна уу?
- d) COVID-19-ийн халдвар авахгүйгээр ажлын байран дээрээ аюулгүй очих ба буцах боломжтой гэдэгтээ итгэлтэй байна уу?

4.4.2.2 Байгууллага гэрээсээ ажиллахтай холбоотой эрсдэлийг системтэйгээр үнэлэх, эрсдэлийг бууруулахад шаардлагатай арга хэмжээ авахын тулд ажилтантай зөвлөлдөхдөө дараах хүчин зүйлийг харгалзан үзвэл зохино. Үүнд:

- a) ажилтны гэр бүлийн нөхцөл байдал (жишээлбэл, хүүхэд асрах, асаргааны бусад үүрэг хариуцлага, гэр бүлийн хүчирхийлэл, COVID-19-ийн халдвар авах эсвэл хүндээр өвчлөх эрсдэл өндөр гэж үзэж буй гэр бүлийн гишүүн);
- b) гэр орон ажил хийхэд тохирсон байдал (жишээлбэл, хэмжээ, бусад хүмүүстэй орон зай хуваалцах, дуу чимээний түвшин, тохирох гэрэлтүүлэг, эргономикийн асуудал);
- с) ажилтан холбогдох систем, мэдээлэлд нэвтрэх боломж (жишээлбэл, имэйл, дундын электрон хөтөч, мэдээллийн сан, холбогдох системийн нэмэгдүүлсэн аюулгүй байдал, гэрээсээ аюулгүй ажиллах заавар);
- d) мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, программ хангамжийг ашиглахад байнгын дэмжлэг үзүүлэх хэрэгцээ (жишээлбэл, онлайн хурлын хэрэгслүүд);
- e) ажилтан гэртээ ажил дээрээ ашигладаг тоног төхөөрөмж түр хугацаагаар авч хэрэглэхийг зөвшөөрөх хэрэгцээ, эсвэл нэмэлт тоног төхөөрөмжөөр хангах (жишээлбэл, компьютер, компьютерын дэлгэц, гар, хулгана, эргономикийн хувьд тохиромжтой сандал, хөлийн тавиур, чийдэн, принтер, чихэвч);
- f) гэрийн нөхцөлд тохирсон ажлын байрыг бий болгох зааварчилгааны хэрэгцээ (жишээлбэл, нуруугаа цэх суух, байнгын хөдөлгөөн хийх);

MNS ISO/PAS 45005 : 2021

г) сэтгэл зүйн эрсдэл (6-р хэсгийг үзнэ үү);

h) хувь хүний болон үл хөдлөх хөрөнгийн даатгал, татварын өр төлбөрт үзүүлэх нөлөө.

Байгууллага нь ажилтан эсвэл түүний гэр бүлийн аль нэг гишүүн COVID-19-ийн халдвар авсан эсвэл хавьталд орсон бол өөрийгөө тусгаарлах эсвэл хөл хорио тогтоох шаардлагатай тохиолдолд юу хийх талаар зааварчилгаа өгөх шаардлагатай.

4.4.3 Бусдын гэрт ажиллах

4.4.3.1 Хэрэв бусдын гэрт хэн нэг гишүүн нь COVID-19-ийн шинж тэмдэгтэй (өөрийгөө тусгаарласан эсвэл хорионд байгаа) эсвэл COVID-19-р хүнд өвчлөх эсвэл халдвар авах өндөр эрсдэлтэй бол ажилтан дараах тохиолдлоос бусад үед энэ гэрт ажил хийж болохгүй. Үүнд:

а) эмнэлгийн болон хувийн асаргаа үзүүлэх (эмнэлгийн болон нийгмийн ажилтан гэх мэт);

б) аюулгүй байдалд үзүүлж буй шууд эрсдэлийг арилгах (жишээлбэл, сантехникч, барилгын ажилтан, цахилгаанчин, хийн инженер яаралтай засвар хийх);

с) хүн хоорондын зай баримтлан хэрэгжүүлж болох эсвэл эмзэг хүнийг хамгаалах талаар авсан бусад арга хэмжээний дагуу бусдын гэрт үүссэн асуудлыг шийдвэрлэх.

4.4.3.2 Ажилтныг бусдын гэрт ажил хийхэд бэлтгэхдээ байгууллага дараах арга хэмжээ авах шаардлагатай. Үүнд:

а) ажилтны гэрийн хэн нэг гишүүнд COVID-19-ийн шинж тэмдэг илэрсэн, өөрийгөө тусгаарласан эсвэл хөл хорионы дэглэмтэй байгаа эсэх, эсвэл COVID-19 халдвар авах өндөр эрсдэлтэй тул түүнийг бусад хүмүүсээс тусгаарлахыг зөвлөсөн эсэхийг шалгах;

б) ажлыг цахим эсвэл алсын зайны (видео эсвэл утасны зөвлөгөө гэх мэт) төхөөрөмж ашиглан хийх талаар судлах;

с) ажил эхлэхээс өмнө ажил хэрхэн гүйцэтгэх, эрсдэлийг багасгах ерөнхий аргуудыг хэлэлцэн тохиролцох зорилгоор айл өрхүүдтэй харилцаа тогтоох (жишээлбэл, биеийн контактгүй барилга руу нэвтрэх, айлд орохоосоо өмнө гараа ариутгах ба гарахаасаа өмнө гараа угаах, айлд хүн хоорондын зай барих, хаалганы бариултай харьцах харьцааг багасгахын тулд дотор хаалгыг онгорхой байлгах);

д) нийтийн тээврийн хэрэгслээр зорчих, ашиглах явдлыг багасгах зорилгоор боломжтой бол ажилтанд ойрхон айлд ажиллах хуваарь хийх;

е) ажилтныг зохих ХХХ, нүүрний хаалт, маск, гар ариутгагч, цэвэрлэх хэрэгсэл, ариутгалын бодисоор хангах;

ф) давтан очих шаардлагатай эсвэл нэг ажил үргэлжлүүлэн хийх бол (жишээлбэл, асаргаа шаардлагатай нэг хүн, нэг цэвэрлэгч) үйл ажиллагааны төрөл, ажилтны тухайн өрхөөс гадуур бусад хүмүүстэй харьцах харьцааг харгалзан ижил хувь хүн, хос эсвэл жижиг багийг өрхөд хуваарилах.

4.4.3.3 Байгууллага нь нэг буюу хэд хэдэн хүн COVID-19-ийн халдвар авсан эсвэл COVID-19 өвчтэй хүнтэй хавьтсан тохиолдолд ажилтан өөрийгөө тусгаарлах, хөл хорио тогтоох нөхцөл байдлыг зохицуулах талаар тодорхой бодлого, үйл явцыг бий болгож, мэдээлнэ (9-р бүлгийг үзнэ үү).

4.4.4 Олон байршилд эсвэл хөдөлгөөнт ажлын байранд ажиллах

Байгууллага гэртээ эсвэл ажлын байранд тогтмол байрлаж гүйцэтгэх боломжгүй үүрэг бүхий ажилтанд (жишээлбэл, жолооч, нийгмийн болон хувийн асрамжийн үйлчилгээ үзүүлэгч, цэвэрлэгч, шуудангийн ажилтан, хүргэлтийн ажилтан, замын цагдаа, засвар, үйлчилгээний ажилтан) аюулгүй ажиллах, аялах, бусадтай харьцахдаа өвчин дамжихаас сэргийлэх зорилгоор дэмжлэг, удирдамж, хангалттай нөөцөөр хангахад анхаарна.

Байгууллага нь ажилтан ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөлтэй зөвлөлдөн, хөдөлгөөнт үүрэгтэй ажилтан янз бүрийн нөхцөлд зохих ёсоор ажиллахын тулд өөрсдийн тохирсон

шийдвэр гаргах бүрэн мэдээлэлтэй бөгөөд итгэлтэй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Байгууллага хөдөлгөөнт ажил хийж буй ажилтанд дараах зөвлөмжийг өгч, хэрэгжилтийг хангуулах шаардлагатай. Үүнд:

- a) хүн хоорондын зайн болон эрүүл ахуйн дэглэм мөрдөх (10-р бүлэг үзнэ үү);
- b) хүн хоорондын зай барих боломжгүй эсвэл бусад хүмүүс хүн хоорондын зай барихгүй байх нөхцөл байдалд хэрхэн ажиллах зааврыг дагаж мөрдөх;
- c) бусад байгууллагад аюулгүй байдал, бусад шалтгаанаар ХХХ, маск, нүүрний хаалт авах шаардлагатай бол хэрхэн ажиллах зааврыг дагаж мөрдөх;
- d) нөхцөл байдлаас шалтгаалан ХХХ, маск, нүүрний хаалт, гар ариутгагч, цэвэрлэгээний бодис, ариутгалын бодис зэргийг хангалттай хэмжээгээр авах боломжтой байх нөхцөлийг хангах;
- e) нийтийн бие засах газар зэрэг нөөцөд хэрхэн хүрэх, аюулгүй ашиглах, хоол хүнс, ундааг хэрхэн аюулгүй олж авах, хэрэглэх талаар заавар мөрдөх;
- f) шаардлагатай бол хавьтлыг тодорхойлох явцдаа очсон газруудын тухай баримтжуулсан мэдээллийг хадгалах;
- g) хэрэв ажилтан эсвэл бусад оролцогч талууд COVID-19-ийн халдвартай хүнтэй хавьталд орсон тохиолдолд хавьтлыг үр дүнтэй илрүүлэх ажиллагааг дэмжих зорилгоор тэдэнтэй удаан хугацааны турш холбоотой байсан эсвэл ойрын хавьталд байсан хүмүүсийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг боломжтой бол хадгалах.

4.5 Үүрэг

4.5.1 Ажилтныг хаана ажиллуулах шийдвэр гаргах болон түүний үүрэг, үйл ажиллагааг үнэлэхдээ байгууллага нь ажилтны дараах төлөв байдлыг харгалзан үзнэ. Үүнд:

- a) COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19 хүндээр өвчлөх эрсдэлтэй эсэх;
- b) COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19 хүндээр өвчлөх эрсдэлтэй гэж үздэг хүнийг асардаг;
- c) COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19 хүндээр өвчлөх эрсдэлтэй гэж үздэг хүнтэй хамт амьдардаг;
- d) хөгжлийн бэрхшээлтэй эсвэл бусад нөхцөл байдлаас шалтгаалан нэмэлт боломжит зохицуулалт хийлгэх эрхтэй, хэрэгтэй эсвэл шаардлагатай (жишээлбэл, аутизм, жирэмслэлт, харьцангуйгаар нөлөөнд өртсөн цөөнхийн бүлгүүд гэх мэт мэдрэлийн эмгэгүүд);
- e) сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах нэмэлт дэмжлэг хэрэгтэй.

Байгууллага нь гэртээ үр дүнтэй гүйцэтгэх боломжтой ажил үүрэг бүхий ажилтныг гэрээсээ ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.

Үүнийг үр дүнтэй болгохын тулд байгууллага 4.4.2-т заасны дагуу тодорхойлсон арга хэмжээ авах ба ажилтанд дэмжлэг үзүүлэх, сайн сайхан байдалд хяналт тавих, ажлын байранд байгаа болон бусад ажилтантай харилцаа холбоо тогтоох зорилгоор виртуал эсвэл утасны уулзалт тогтмол зохион байгуулах шаардлагатай.

Байгууллага нь гэрээсээ ажиллаж байгаа ажилтнаас ямар үр дүн хүлээх, тэд юу хийх ёсгүй талаар тодорхой болгож, ажилтны хувийн хэрэгцээг аль болох хангаж ажиллана.

4.5.2 Ажлын байранд биеэр байх шаардлагатай ажилтны хувьд байгууллага дараах арга хэмжээ авна. Үүнд:

- a) бизнесийн тасралтгүй байдал, байгууламжийн аюулгүй байдлын менежмент эсвэл зохицуулалтын шаардлагын дагуу гэрээс гүйцэтгэх боломжгүй эгзэгтэй үүргийг тодорхойлох;

MNS ISO/PAS 45005 : 2021

b) гэр орны нөхцөл байдал, нарийн мэргэжлийн тоног төхөөрөмж байхгүй шалтгаанаар гэрээсээ ажиллах боломжгүй чухал үүрэг гүйцэтгэдэг ажилтныг тодорхойлох;

c) ямар ч үед аюулгүй, үр дүнтэй ажиллах зорилгоор ажлын байранд биеэр байх ажилтны хамгийн бага тоог тодорхойлох;

d) үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулахыг тодорхойлох (жишээлбэл, ажлын ээлж солилцох эргэлтийг багасгах, ажилтан ээлжийн туршид нэг багц тоног төхөөрөмжөөр нэг ажил хийх, ажлын уян хатан цагийг бий болгох).

Байгууллага нь COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19 хүндээр өвчлөх эрсдэлтэй гэж үзэж буй, гэрээсээ ажил хийх боломжгүй ажилтанд биеэр ирж ажиллах ажлын байранд хамгийн найдвартай ажил үүргийн сонголтыг санал болгоно. Ажилтан энэ ажил үүргийг хийхдээ хүн хоорондын зайн дүрмийг байнга баримтлах шаардлагатай.

Хэрэв COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19 хүндээр өвчлөх эрсдэлтэй гэж үзэж буй ажилтан хүн хоорондын зайн дүрэм мөрдөх боломжгүй бол байгууллага ажилтан ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөлтэй зөвлөлдөж, аюулгүй байдал, хяналтын нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлж, хүлээн зөвшөөрөгдөх эрсдэлийн түвшинд байгаа эсэхийг үнэлнэ.

Байгууллага нь COVID-19-тэй холбоотой аюулгүй байдлын арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлэх, хадгалах, дээд удирдлагад асуудлыг тайлагнах тусгай үүрэгтэй ажилтнуудыг (эсвэл жижиг байгууллагад нэг ажилтан) томилох асуудлыг авч үзэх шаардлагатай.

Хэрэв ажилтанд шинэ үүрэг, даалгавар хуваарилсан бол ажилтан эдгээр үүргийг гүйцэтгэх чадвартай байх хангалттай сургалт, дэмжлэгийг байгууллагын зүгээс үзүүлнэ.

Байгууллага бусад бүлэгтэй харьцуулахад зарим бүлэгт (жишээлбэл, асаргаа үзүүлдэг ажилтан, шашны үүрэг хүлээсэн ажилтан, хөгжлийн бэрхшээлтэй ажилтан, жирэмсэн эмэгтэй) үзүүлэх нотлогдоогүй сөрөг нөлөөллийн хувьд авсан аюулгүй байдлын арга хэмжээ эсвэл хяналтын хэрэгжилтэд мониторинг хийх шаардлагатай.

4.6 Үйл ажиллагаа

Хэрэв эгзэгтэй ажил гүйцэтгэхэд хүн хоорондын зайн дүрэм мөрдөх боломжгүй бол байгууллага COVID-19-ийг ажилтнуудын дунд болон ажлын байранд бусадтай хавьтах замаар дамжих эрсдэлийг бууруулах бүх боломжит арга хэмжээг авна.

Үйл ажиллагаагаа сэргээхээс өмнө байгууллага дараах бууруулах арга хэмжээ авах хэрэгтэй. Үүнд:

a) ойрхон зайд ажиллах хүмүүсийн тоог хязгаарлах зорилгоор байнга хамт ажиллах цөөн хүнтэй баг эсвэл хос бий болгох; баг эсвэл хосыг нэг нэгж гэж үзэх ба хэрэв аль нэг гишүүн COVID-19 өвчний шинж тэмдэг илэрвэл тухайн хэсгийн бүх гишүүд албан ёсны удирдамжийн дагуу өөрсдийгөө тусгаарлах, хөл хорио тогтоох;

b) үйл ажиллагааг аюулгүй гүйцэтгэх зорилгоор ажлын зааврыг шинэчлэх (жишээлбэл, арга хэмжээ үргэлжлэх хугацааг аль болох богиносгох, хүмүүсийг тусгаарлахын тулд дэлгэц эсвэл хаалт, ашиглах, өөдөөсөө харж биш харин нуруугаар нь харуулж эсвэл зэрэгцээ суулгах);

c) хүн хоорондын зайн дүрэм мөрдөх боломжгүй үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ тодорхой бүсүүдийг тогтоох;

d) ганцаараа аюулгүй ажиллах боломжтой ажилтан хүн хоорондын зай баримтлах зорилгоор тусгаарлагдсан орон зай ашиглах;

e) ажилтан бие биедээ эсвэл бусад хүмүүст, түүний дотор олон нийтэд шууд дамжуулдаг (жишээлбэл, ажлын мэдээлэл, сэлбэг хэрэгсэл, дээж, худалдаж авсан зүйлс) үйл ажиллагааг тодорхойлж, хэрэв боломжтой бол шууд харьцах холбоог арилгах үйл явцыг бий болгох (жишээлбэл, үлдээх, эсвэл шилжүүлэх бүс гэх мэт);

f) зохих ХХХ-ийн хангамж, тэдгээрийг зөв ашиглах талаар зөвлөгөө өгөх.

4.7 Онцгой байдлын үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ

Байгууллага нь болзошгүй гэнэтийн ослын үед бэлтгэх, шаардлагатай бол одоо байгаа үйл явцыг үнэлэх, өөрчлөлт оруулах шаардлагатай. Байгууллага жишээлбэл дараах асуудлыг тооцсон байна. Үүнд:

- а) онцгой байдлын үйл явц (жишээлбэл, бусад хүмүүстэй ойр зайнаас харьцах харилцааг хязгаарласан багийн нүүлгэн шилжүүлэлт, багуудын хоорондын зайг нэмэгдүүлэх зорилгоор ажилтан болон бусад холбогдох оролцогч талууд хэрхэн цуглах цэгт цугларах зохицуулалт, удирдамж);
- б) тусламж шаардлагатай эсвэл нүүлгэн шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх шаардлагатай хүмүүсийг яаралтай нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний дүн шинжилгээ (шаардлагатай бол нэмэлт ХХХ өгөх);
- с) өвчин, өөрийн тусгаарлалт эсвэл хөл хорионы дэглэм нь ажлын байран дээрх бэлтгэгдсэн ажилтны хомсдолд хүргэж болзошгүй тул онцгой байдалд хариу үзүүлэх чадвартай нэмэлт хүмүүсийг сургаж бэлтгэх хэрэгцээ;
- д) эмнэлгийн яаралтай тусламж шаардлагатай эсвэл аваар ослын үед анхны тусламж үзүүлэх нөөц түүний дотор зохих ХХХ-ээр хангах асуудал;
- е) түрэмгий, догшин хүмүүстэй харьцах талаар тодорхой удирдамж өгөх хэрэгцээ.

Аюул тохиолдох магадлалтай онцгой байдлын үед (жишээлбэл, химийн бодис асгарах, гал түймэр, хорлон сүйтгэх ажиллагаа) хүн хоорондын зай барих боломжгүй байж болно.

Амь насаа аврах асуудлыг нэн тэргүүнд анхаарах хэрэгтэй; гэхдээ байгууллага нь боломжийн хэмжээнд онцгой байдлын үед COVID-19-ийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах зорилгоор яаралтай тусламжийн төлөвлөгөөндөө нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай.

Байгууллага нь галын сургуулилт, загварчлал болон бусад дадлагын үеэр хүн хоорондын зайтай холбоотой үүсэж болзошгүй нэмэлт эрсдэлийг үнэлэх, онцгой байдлын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийн талаарх мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авна.

Байгууллага эдгээр дасгал, сургуулилыг төлөвлөхдөө ажлын байрнаас нүүлгэн шилжүүлэх зэрэг нөхцөл байдалд хүн хоорондын зайн дүрэм мөрдөх боломжгүй бол аюулгүй байдлын нэмэлт хяналт, арга хэмжээг авч үзнэ.

Байгууллага нь онцгой байдлын үед бусдад тусламж үзүүлдэг ажилтанд яаралтай тусламжийн дараа гар угаах, халдваргүйтгэл хийх зэрэг эрүүл ахуйн нэмэлт, яаралтай арга хэмжээ авах шаардлага тавина.

4.8 Хязгаарлалтын өөрчлөлттэй холбоотой төлөвлөлт

4.8.1 Байгууллага нь COVID-19-тэй холбоотой одоо байгаа болон дараа гарч болзошгүй эрсдэлийг хянаж, хязгаарлалтыг богино хугацаанд өөрчлөх магадлалтай тохиолдлуудын төлөвлөлтийг хийх шаардлагатай (хязгаарлалтад орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын арга хэмжээ нөлөөлж болно).

Байгууллага нь аль болох үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд хязгаарлалтын өөрчлөлтөд хурдан бөгөөд үр дүнтэй хариу үзүүлэхийн тулд авах арга хэмжээгээ тодорхойлсон байна.

Төлөвлөлт хийхдээ хязгаарлалт нэмэгдсэн эсвэл өөр хязгаарлалтыг багтаасан эсвэл хязгаарлалтыг цуцлах зэрэг янз бүрийн болзошгүй нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

Төлөвлөлтийг ажилтан ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөлтэй зөвшилцөж хийнэ (4.2-ыг үзнэ үү).

Төлөвлөлтөд байгууллага дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

MNS ISO/PAS 45005 : 2021

а) ажлын байранд биеэр ирж ажиллах ажилтны тоог хамгийн бага хэмжээнд байлгах, эсвэл гэрээс ажил үүрэг гүйцэтгэх замаар хүн хоорондын зайн дүрмийг баримтлан гүйцэтгэж болох үндсэн үйл ажиллагаанд төвлөрч бусад үйл ажиллагааг хязгаарлах;

б) байгууллага хязгаарлалтын хугацаанд үйл ажиллагаагаа үргэлжлүүлэхийн тулд үйл ажиллагааг өөрчилж болох эсэх;

в) шаардлагатай арга хэмжээг авч үзэхийн тулд (жишээлбэл, нэмэлт арга хэмжээ авах, ажил өөрчлөн зохион байгуулах зорилгоор үйл ажиллагааг зогсоох гэх мэт) үйл ажиллагааг бүрэн буюу хэсэгчлэн түдгэлзүүлэх шаардлагатай эсэх;

д) өөр үйл ажиллагаа хэрэгжүүлэх боломжтой эсэх;

е) ажилтны онцлог хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан тэдэнд үзүүлэх нөлөөлөл;

ф) байршлын янз бүрийн хязгаарлалтад ажилтан бүрд хэрхэн нөлөөлж болох (жишээлбэл, орон нутгийн, бүс нутгийн, үндэсний болон олон улсын хилээр нэвтрэх шаардлагатай ажилтан);

г) нийлүүлэлтийн сүлжээнд үзүүлж болзошгүй нөлөөлөл ба тэдгээрийг зохицуулахад шаардлагатай арга хэмжээ;

н) түнш байгууллага, нэг байгууламжид хамт байрлаж буй байгууллага болон бусад холбогдох оролцогч талуудтай хамтран ажиллах, харилцаа холбоо тогтоох хэрэгцээ.

4.8.2 Төрөл бүрийн хязгаарлалтын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөнд дараах зүйлийг тусгасан байх шаардлагатай. Үүнд:

а) дараах ажилтнуудыг тодорхойлж, мэдэгдэх:

- 1) ажлын байран дээр биеэр байх шаардлагатай;
- 2) гэрээсээ ажиллах шаардлагатай;
- 3) ажиллах боломжгүй;

б) ажлын цаг, цалин хөлс болон бусад нөхцөлд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэх;

в) хязгаарлалтын өөрчлөлт нь үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх талаар үйлчлүүлэгч болон бусад сонирхогч талд мэдээлэх (жишээлбэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, апп, тэмдэг, вэбсайтаар дамжуулан).

Тодорхой хязгаарлалт тавьсан бол (жишээлбэл зочлох байгууллагуудыг эсвэл ойрын хавьтал бүхий үйлчилгээг хаасан) байгууллага нь огт ажиллах боломжгүй байх магадлалтай ажилтан тус бүрд үзүүлэх нөлөөг харгалзан үзэх ба цалин хөлс, хөдөлмөрийн нөхцөлд нөлөөлж болзошгүй эсвэл болзошгүй нөлөөллийн талаар тэдэнд мэдээлнэ.

Хязгаарлалтыг гэнэт суллахад ажилтанд үзүүлэх нөлөөллийг мөн анхаарч үзэх хэрэгтэй(жишээлбэл, хүүхэд асрах үүрэг хариуцлагын улмаас богино хугацаанд ажилдаа эргэж орох чадвар, COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19 хүндээр өвчлөх эрсдэл өндөр гэж үзсэн ажилтан, эсвэл өндөр эрсдэлтэй бусад хүмүүстэй нэг гэрт амьдардаг, эсвэл энэ үед өөрийгөө тусгаарласан эсвэл хөл хорионы дэглэмд байгаа ажилтан).

Төлөвлөгөөг ажилтан болон холбогдох бусад оролцогч талуудад аль болох богино хугацаанд мэдэгдсэн байна.

5 COVID-19-ийн сэжигтэй эсвэл батлагдсан тохиолдол

5.1 Ерөнхий зүйл

Байгууллага нь COVID-19-ийн сэжигтэй, батлагдсан тохиолдлыг удирдах үйл явцыг боловсруулж, хэрэгжүүлнэ.

Байгууллага нь COVID-19-ийн халдвар ажлын байранд нэвтрэх боломжийг хязгаарлах зорилгоор байгууламжид ирж буй хүмүүсийг үнэлэх, өвчний шинж тэмдэг илэрсэн, өвчний тархалт ихтэй бүс нутгаар саяхан аялаад буцаж ирсэн эсвэл COVID-19-ийн халдвар авсан

хүмүүстэй хавьталд орсон хүнийг нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Дээд удирдлага, бүх түвшний менежерүүд ажилтнуудаа COVID-19-ийн шинж тэмдэг илэрвэл даруй өөрийгөө тусгаарлах арга хэмжээ авах, шаардлагатай бол хөл хорио тогтооход нь дэмжлэг үзүүлэх, мөн холбоо харилцаа, өөрийгөө тусгаарлах эсвэл хөл хорио тогтоох, ажилдаа эргэж орохтой холбоотой хэрэгжүүлж буй үйл явц, тэднээс юу хүлээж байгааг ойлгоход нь туслалцаа үзүүлнэ.

Байгууллагад COVID-19-ийн халдвар гарсан бол холбогдох зохицуулалт, эрүүл мэндийн байгууллагуудад мэдэгдэх шаардлагатай (13.2.2-ыг үзнэ үү).

5.2 Ажлын байранд гарсан өвчлөлийг удирдах

COVID-19-ийн халдварыг багасгах, анхан тусламж өгөх хүмүүс, түүний дотор анхны тусламж үзүүлэх ажилтан, эмчлэгдэж буй хүнийг хамгаалахын тулд ажлын байран дээр бие тавгүйрхсэн хэн бүхнийг COVID-19-ийн болзошгүй тохиолдол гэж үзнэ.

Байгууллага нь хувь хүний нөхцөл байдлыг харгалзан (жишээлбэл, хэрэв ажилтан COVID-19-ийн халдвар авах эсвэл COVID-19-ээр хүндээр өвчлөх эрсдэл өндөртэй байх магадлалтай, эсвэл өндөр эрсдэлтэй хүнтэй хамт амьдардаг эсвэл ажилтан өөрөө халдвар нэмэгдэх вий гэсэн айдастай байвал) ажил үүргээ үргэлжлүүлэх хүсэл, боломжтой эсэхийг тодруулахын тулд анхны тусламжийн ажилтнуудтай зөвлөлдөх шаардлагатай.

Байгууллага дараах арга хэмжээ авна. Үүнд:

а) тохиромжтой ХХХ (нүүрний хаалт, бээлий, халат) болон маскаар хангаж, анхны тусламж үзүүлэхэд эдгээр хэрэгслийг хэрхэн ашиглах талаар зааварчилгаа өгөх (дохионы хэлээр ярьдаг хүмүүст анхаарлаа хандуулах хэрэгтэй байх нөхцөлд нүүрний тунгалаг хаалт хэрэглэх болон хүн хоорондын зай барих дүрмийг хамтад нь хэрэглэнэ; нүүрний тунгалаг хаалт хэрэглэх, хүн хоорондын зай барих боломжгүй бол бичгээр зэрэг харилцааны бусад хэлбэрийг ашиглах хэрэгтэй);

б) өвчтөнд анхны тусламж үзүүлэх үед тусгаарлах эсвэл шаардлагатай бол ажлын байрнаас тээвэрлэх ажлыг зохион байгуулах (жишээлбэл, гэр бүлийн гишүүний тээврийн хэрэгсэл ашиглах);

с) нөлөөлөлд өртсөн хүнд маск өгөх (амьсгалын замын суурь өвчтэй хүмүүст анхаарал хандуулах хэрэгтэй) мөн гараа угааж, ариутгах шаардлага тавих;

д) нөлөөлөлд өртсөн хүнийг тээврийн аюулгүй арга хэрэгсэл (жишээлбэл, боломжтой бол нийтийн тээврийн хэрэгслээс зайлсхийх) ашиглан ажлын байрыг орхин тохиромжтой аюулгүй газар (жишээлбэл, гэр эсвэл эмнэлгийн байгууллага) очихыг зөвлөх;

ТАЙЛБАР 1: Үүнийг орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний хэмжээнд гаргасан дүрэм, журамд зааж өгч болно.

е) нөлөөлөлд өртсөн хүнд шинж тэмдэг илэрсэн бол COVID-19-ийн шинжилгээ өгч, хариуг байгууллагад мэдэгдэхийг зөвлөх;

ф) нөлөөлөлд өртсөн ажилтан бусад ажилтан эсвэл үйлчлүүлэгчтэй хавьталд орсон эсэхийг тогтоож (жишээлбэл, багаар эсвэл хосоороо хүн хоорондын зай бариагүй ажил гүйцэтгэж байсан, ойрын зайнаас үйлчилгээ үзүүлсэн), COVID-19-ийн халдвар авсан байж болзошгүй талаар эдгээр ажилтан эсвэл үйлчлүүлэгчид мэдээлэх, болзошгүй халдварын эх үүсвэрийн нууцлалыг хадгалах, хавьталд орсон ажилтныг нэн даруй өөрийгөө тусгаарлах, хөл хорионы дэглэмд оруулахад дэмжлэг үзүүлэх;

г) хэрэв COVID-19-өөр халдвар авсан нь батлагдсан бол хавьталд орсон бусад ажилтны талаарх мэдээллийг хадгалах, мөн илүү өргөн хэмжээнд өөрийгөө тусгаарлах шаардлага тавих;

MNS ISO/PAS 45005 : 2021

h) нөлөөлөлд өртсөн ажилтан байсан газрыг аль болох богино хугацаанд тусгаарлах, бие засах газар зэрэг нийтийн эзэмшлийн газар, мөн гадаргууд нь байнга хүрдэг тоног төхөөрөмжид онцгой анхаарч, цэвэрлэх, ариутгах;

i) нөлөөлөлд өртсөн байрыг цэвэрлэж, ариутгал хийдэг ажилтан эрсдэлийн үнэлгээнд үндэслэсэн зохих ХХХ-ийг ашиглаж, аюулгүй ажиллагааны дадлыг дагаж мөрдөхөд анхаарах;

j) жишээлбэл, ажлын байранд COVID-19-ийн хоёр ба түүнээс дээш тохиолдол батлагдсан тохиолдолд эрүүл мэндийн байгууллагуудад мэдээлэх;

ТАЙЛБАР 2: Үүнийг орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний хэмжээнд гаргасан дүрэм, журамд зааж өгч болно.

k) COVID-19-өөр өвчилсөн ажилтан ажлын байранд аюулгүй буцаж ирэх талаар тодорхой зааварчилгаа өгөх;

l) нөхцөл байдлаас шалтгаалан ажилдаа эргэж очих ажлыг хөнгөвчлөх, байнгын дэмжлэг үзүүлэх, нөхөн сэргээх талаар авч болох арга хэмжээний талаар мэдээлэл өгөх.

5.3 Гэртээ эсвэл хөдөлгөөнт ажлын байранд өвдсөн ажилтанд тавих хяналт

Байгууллага нь гэртээ эсвэл хөдөлгөөнт ажлын байранд ажиллаж байх явцад COVID-19-ийн шинж тэмдэг илэрсэн ажилтныг удирдах үйл явцыг бий болгосон байна. Байгууллага дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

a) ажилтнууд өвчний шинж тэмдгийг тухайн байгууллагад нэн даруй мэдэгдэхийг зөвлөх;

b) нөлөөлөлд өртсөн хүн тээврийн аюулгүй арга хэрэгсэл (жишээлбэл, боломжтой бол нийтийн тээврийн хэрэгслээс зайлсхийх) ашиглан ажлын байрыг орхин тохиромжтой аюулгүй газар (жишээлбэл, гэр эсвэл эмнэлгийн байгууллага) очих;

ТАЙЛБАР: Үүнийг орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний хэмжээнд гаргасан дүрэм, журамд зааж өгч болно.

c) ажилтан өөрийгөө тусгаарлах, хөл хорионы дэглэмийг мэддэг байх, хэрэгжүүлэхийг шаардах (ажилтан COVID-19-ийн халдвар авсан хүнтэй ойр эсвэл удаан хугацаагаар хавьталд орсон бол);

d) өвчний шинж тэмдэг даамжирч байгаа болон / эсвэл ажилтан хүнд өвчтэй байгаа эсэхийг тогтоохын тулд халдвар авсан ажилтантай тогтмол холбоо тогтоох;

e) хэрэв ажилтны биеийн байдал хангалттай сайн байгаа бөгөөд гэрээсээ үргэлжлүүлэн ажиллах эсвэл энэ хугацаанд өвчний чөлөө авах эсэхээ ойлгож, мэддэг байх;

f) ажилтан өөрийгөө тусгаарласны дараа эсвэл эдгэрсний дараа ажилдаа эргэж орох үйл явцыг ойлгодог байх;

g) шаардлагатай бол COVID-19-ийн халдвар авсны дараа ажилдаа эргэн орж буй ажилтныг дэмжих зорилгоор тэдний бие махбодын болон сэтгэлзүйн хэрэгцээг харгалзан холбогдох тохируулга хийх.

5.4 Оношилгоо, хавьтал илрүүлэлт, хөл хорионы дэглэм

Байгууллага нь оношилгоо, хавьтал илрүүлэлт, хөл хорионы дэглэмийн талаар гарсан холбогдох хууль тогтоомж эсвэл холбогдох зохицуулалт, эрүүл мэндийн байгууллагуудын удирдамжийг бүрэн мэдсэн байхад шаардлагатай бүх арга хэмжээ авна.

ТАЙЛБАР: Орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний дүрэм журам мөрдөж болно.

Түүнээс гадна байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

a) шинж тэмдэг илэрсэн Ажилтныг аль болох богино хугацаанд шинжилгээнд хамруулах;

- b) ажил үүргийнхээ дагуу бусад хүмүүстэй өргөн хүрээнд харьцдаг ажилтан, түүнчлэн шинж тэмдэггүй Ажилтныг шинжилгээнд тогтмол хамрагдахыг дэмжих;
- c) эрүүл мэнд, шинж тэмдгийг хянах апп, судалгааны сайтыг ашиглахыг дэмжих;
- d) байгууллагад зочилсон ажилтан эсвэл хүмүүстэй холбоо тогтоох мэдээллийг боломжийн хэмжээнд байлгах, нууцлалыг хүндэтгэх;
- e) шаардлагатай тохиолдолд ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудыг дараах үндэслэлээр хөл хорионы дэглэм тогтоохыг шаардах:

1) хөдөлгөөний хязгаарлалт;

2) хавьтал илрүүлж буй хүмүүс, эрүүл мэндийн байгууллагуудын зөвлөгөө эсвэл цахим сүлжээ эсвэл бусад харилцаа холбооны хэрэгслээр ирүүлсэн мэдээлэл;

f) гэртээ эсвэл өөр газар ажил үүргээ гүйцэтгэх явцад хөл хорионы дэглэмд орсон бол хувь хүний хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан үзэх ба шаардлагатай бол хөл хорионы зардлын дэмжлэг үзүүлэх;

g) ажлын бус үеэр хөл хорионы дэглэмд хамрагдах шаардлагатай(жишээлбэл, хувийн аяллаас буцаж ирэхэд шаардлагатай хөл хорионы дэглэм) ажилтанд боломжийн тохируулга хийх, хэрэв шаардлагатай бол жил бүр тусгай болон цалингүй чөлөө авах боломжийг олгох;

h) цар тахлын үед аялал жуулчлалын талаар баримтлах бодлогоо нийт ажилтанд ойлгуулах.

6 Сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдал

6.1 Байгууллага нь ажилтны сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд цар тахлын үзүүлэх нөлөөллийг удирдах үйл явцыг бий болгосон байна.

Сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдалд сэтгэл зүйн хямрал ба ажлын байрны стресстэй холбоотой дараах аюул нөлөөлж болзошгүй, тухайлбал:

a) тодорхойгүй байдал (жишээлбэл, бидний өмнө юу хүлээгдэж байгаа, тохиролцоо хэр удаан үргэлжилж болох, цалин хөлс эсвэл ажлын цагт үзүүлэх нөлөө);

b) ажлын ачаалал ба хурд (жишээлбэл, хэт их эсвэл хэт бага ажил, ажлын хэв маяг өөрчлөгдсөнөөс болж үйл ажиллагаа удаан үргэлжилж байгаа ч гэсэн богино хугацаанд хүрэх хүлээлт);

c) ажлын цаг (жишээлбэл, урьдчилан таамаглах боломжгүй цаг, богиносгож, уртасгасан цаг, ээлжийн шинэ горим);

d) үүрэг хариуцлага тодорхой бус, хоёрдмол утгатай байдал (жишээлбэл, хүлээгдэж буй үүрэг, хариуцлагыг өөрчлөх, шинэ үүрэг хариуцлага, ойлгомжгүй байдал);

e) хяналтгүй байдал(жишээлбэл, эрсдэлийн түвшин огцом өөрчлөгдөж, гэнэтийн хэрэгжилт эсвэл хязгаарлалтыг зөөлрүүлэх эсвэл ажлын хэв маягийг өөрчлөхөд хүргэх);

f) нийгмийн халамж, дэмжлэг дутмаг (жишээлбэл ганцаардал, тусгаарлалт, харилцааны асуудал);

g) удаан хугацааны тусгаарлалт, алслагдсан байрлалд ажилласны үр дагавар (жишээлбэл, дэлгэцийн нөлөөлөл, ядрах, уйдах, анхаарал төвлөрөхгүй байх, нойргүйдэх);

h) ажлын байр хадгалахтай холбоотой асуудал (жишээлбэл, ажлын байраа алдах, санхүүгийн дотоод асуудалд санаа зовох);

i) ажил, гэр бүлийн амьдралыг зохицуулахад тулгардаг бэрхшээлүүд(жишээлбэл, асрах үүрэг, гэр бүлийн онцгой байдал, ажлын бус цагаар ажиллах шаардлага);

MNS ISO/PAS 45005 : 2021

ж) бусад хүмүүстэй ойрхон давтамжтай, удаан хугацаанд хийсэн харилцаанаас үүдсэн өндөр эрсдэлтэй тодорхой үүрэг (жишээлбэл, тэргүүн шугамд ажилдаг, олон нийттэй харилцах, явуулын ажил);

к) ажилтны онцгой нөхцөл байдал (жишээлбэл, эмзэг бүлэгт хамаарах, гэр бүлээ алдах, хүнд өвчин тусах).

6.2 COVID-19-тэй холбоотой сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлын эрсдэлийг удирдахын тулд байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

а) ажилтан бүр өөр өөрийн асуудалтай, сэтгэлийн түгшүүр, бэрхшээлтэй байдаг бөгөөд үүнийг нь хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх замаар итгэл, халамж, дэмжлэг үзүүлэх соёл бий болгох;

б) ажилтны асуудал, сэтгэл зовоож буй түгшүүрийн талаар ярилцах, дэмжлэг үзүүлэх арга замыг тодорхойлох зорилгоор ганцаарчилсан уулзалт (зайнаас эсвэл биечлэн аль тохирох хэлбэрээр) тогтмол зохион байгуулах;

в) бүлэг ажилтантай хийх уулзалтыг зайнаас эсвэл биечлэн тогтмол зохион байгуулах;

д) ажлын уян хатан цаг, амралтын хугацаа тогтоох;

е) ажилтантай зөвлөлдсөний үндсэн дээр ажлын уян хатан байдлын хэрэгцээг харгалзан тэдний ажиллах боломжтой, бэлэн байх ёстой гэж үзсэн үеийн ажлын ба ажлын бус цагийн хоорондын эрүүл хил хязгаарыг тогтооход тэдэнд туслах;

ф) хэрэв боломжтой бол ажилтан ажлын хурд, дуусгах хугацааг өөрөө хянах боломжийг олгох;

г) байгууллагын одоогийн нөхцөл байдал, ажилтанд нөлөөлж болзошгүй төлөвлөсөн өөрчлөлтийн талаар тогтмол, тодорхой, үнэн зөв мэдээлэл өгөх;

х) байгууллагаас шаардлагагүй гэж үзсэн ч ажилтан ажлын байран дээр байх айдас, болгоомжлолд чиглэсэн, тохирсон ХХХ, маск, нүүрний хаалт өгөх болон бусад хяналтын арга хэмжээ авах талаар анхаарах;

и) ажилтан өөрийн сэтгэл зүйн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг удирдахад туслах нэмэлт нөөцийг санал болгох (жишээлбэл, онлайн хөтөлбөр, вэбсайт, нас баралт, гэмтлийн талаар зөвлөгөө өгөх, санхүүгийн зөвлөгөө өгөх мэргэжлийн хүмүүст хандах).

ТАЙЛБАР: Сэтгэл зүйн эрүүл мэндийн менежментийн талаарх нэмэлт зааврыг ISO 45003 ба ISO 10075 цувралд өгсөн болно.

7 Оролцоо

Байгууллага нь COVID-19-ийн хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалд үзүүлэх эрсдэлийг удирдах зорилгоор арга хэмжээ авахдаа ажилтны янз бүрийн бүлэг болон бусад холбогдох оролцогч талуудад үзүүлэх нөлөөллийг харгалзан үзсэн байна.

Жишээлбэл байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

а) дэвшүүлсэн асуудал, тулгамдсан асуудлыг анхааралдаа авч, боломжийн хэрээр хүсэлтийг шийдвэрлэх;

б) гэртээ ажлаа үр дүнтэй гүйцэтгэх чадвартай, ажлын байран дээр ажиллахаас санаа зовж буй ажилтныг гэрээсээ үргэлжлүүлэн ажиллахыг дэмжих;

в) хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээг хангах зорилгоор ажилтны мэдлэгийг дээшлүүлэх, сургалт зохион байгуулах (жишээлбэл, тохиромжтой ариун цэврийн өрөөнд нэвтрэх боломжийг олгох, туслалцаа үзүүлдэг амьтад хэрхэн ажилладаг гэдгийг ойлгох, маск эсвэл нүүрний хаалтаас шалтгаалсан харилцааны бэрхшээлийг бууруулах арга хэмжээ авах);

д) шашны бүлгүүдэд зориулсан байранд аюулгүй нөхцөлийг хангах;

е) боломжтой бол эмзэг бүлгийн ажилтанд учрах эрсдэлийг бууруулах зорилгоор үүрэг, үйл ажиллагааг зохицуулах;

ф) харилцаа холбооны хүртээмж, түүний дотор цахим харилцаа холбоонд нэвтрэх боломжийг хангах(жишээлбэл, вэбсайт, онлайн уулзалт эсвэл захиалгын систем).

Хүртээмжтэй байдал, оролцооны талаарх нэмэлт мэдээллийг В Хавсралтад үзүүлэв.

8 Нөөц

Байгууллага нь COVID-19-тэй холбоотой эрсдэлийг үр дүнтэй удирдахад шаардлагатай нөөцийг тодорхойлж, хангалттай хэмжээгээр бэлэн байлгахад анхаарна. Байгууллага нь зайлшгүй шаардлагатай нөөцийг хадгалах, зохистой менежмент хийх, шаардлагатай тохиолдолд найдвартай нийлүүлэх боломжийг хангасан үйл явцыг бий болгох шаардлагатай.

COVID-19-той холбоотой эрсдэлийг бууруулах зорилго бүхий нөөцийг удирдах чиг үүрэгтэй ажилтныг томилж, бүх ажилтан болон бусад холбогдох оролцогч талуудад мэдэгдэнэ.

Байгууллага нь COVID-19-той холбоотой эрсдэлийг удирдахад шаардлагатай нөөцийн тодорхой хэрэгцээний талаар ажилтантай байнгын яриа хэлэлцээ хийх боломжийг олгох, ажилтан асуудлыг хэрхэн дээш нь тавьж болох талаар үйл явцыг бий болгосон байна.

Байгууллага нь үндсэн үйл ажиллагаагаа эхлүүлэх, үргэлжлүүлэх, хадгалахад шаардлагатай нөөцийг тодорхойлохдоо дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

а) хүний нөөц, үүнд ажилтанд үзүүлэх практик болон сэтгэл зүйн дэмжлэг, өвчин эсвэл өөрийгөө тусгаарласны улмаас буурсан хүний нөөцийг удирдах үйл явц;

б) санхүүгийн нөөц;

с) зохих ХХХ, үүнд цэвэрлэгээ, ариутгал хариуцсан ажилтанд зориулсан тусгай хангамж;

д) гар угаах, гар ариутгах, цэвэрлэх төхөөрөмж болон ариутгалын материал;

е) ариун цэврийн байгууламжийн хангалттай, аюулгүй байдал;

ф) технологи;

г) дэд бүтэц, тоног төхөөрөмж (жишээлбэл, хог хаягдал, ус, эрчим хүчний менежменттэй холбоотой);

h) харилцааны аргууд (9-р зүйлийг үз);

и) ажилтан нэмэлт үүрэг эсвэл үйл ажиллагаа эрхлэх чадвартай байхад чиглэсэн нэмэлт сургалтын хэрэгцээ, сургалт явуулах боломж.

Байгууллага нь түр, удаан хугацаагаар эсвэл халагдсан ажилтнаас шалтгаалан (жишээлбэл, өвчний улмаас, өөрийгөө тусгаарласан эсвэл хөл хорионы дэглэм тогтоосон, ажилгүй болсон гэх мэт)одоо байгаа ажилтны эрүүл мэнд, аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад анхаарна.

Байгууллага нь ажилтан ялангуяа шинэ ажил хийхээр төлөвлөж байгаа бол шаардлагатай үүрэг, үйл ажиллагааг гүйцэтгэж чадах эсэхийг баталгаажуулна.

Байгууллага нь нэмэлт ачааллыг багасгах арга хэмжээ авах ба нэмэлт ачаалал нь зөвхөн богино хугацаанд үргэлжлэхэд анхаарна. Шууд удирдлага ажилтан бүр тохиролцсон ажлын цагаас хэтрэхгүй ажиллаж, амрах, чөлөө авах боломжтой байхаар нөлөөлөлд өртсөн ажилтны ажлын ачаалал, үзүүлж буй нөлөөллийг хянана.

9 Харилцаа холбоо

9.1 Ерөнхий

9.1.1 Байгууллага нь COVID-19-тэй холбоотой эрсдэлийг удирдах үүрэг амлалтаа мэдэгдэх шаардлагатай бөгөөд ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудад дараах зүйлийг мэдээлнэ. Үүнд:

- a) аюулгүй байдлын ерөнхий арга хэмжээ ба хяналт;
- b) хүн нэг бүрийн болон ажилтны бүлгүүдийн хэрэгцээг харгалзан ажиллах шаардлагатай арга хэлбэрүүд;
- c) тэд юу хийх шаардлагатай;
- d) тэд байгууллагаас юу хүлээж болох;
- e) асуудал, аюулгүй байдлын талаар хэрхэн мэдээлэх.

Байгууллага нь цар тахлын үеийн бодлого, үйл ажиллагааны тохиролцсон арга хэлбэрт тохирсон арга хэмжээ авч байгаа тухайгаа нотлон харуулахын тулд дээд түвшний удирдлага бүх түвшний ажилтнуудтай тогтмол харилцаа холбоо тогтоох нөхцөлийг бүрдүүлнэ.

9.1.2 Байгууллага нь албан болон албан бус харилцааны аргуудыг хослуулан ашиглах ба (жишээлбэл, дотоод сүлжээ, вэбсайт, имэйл, тэмдэг, зураг, утасны дуудлага, аудио зар, видео бичлэг) мэдээлэл нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, төрөлх хэлээр ярьдаггүй хүмүүс, бичиг үсгийн янз бүрийн түвшний хүмүүст хүртээмжтэй, ойлгогдохуйц хэлбэртэй байна. Байгууллага нь буруу ойлголт өгөхөөс зайлсхийхийн тулд стандартчилагдсан тэмдгийг аль болох ашиглана.

Харилцаа холбооны өргөн хэрэглэгддэг аргыг ашиглахдаа янз бүрийн ажилтны хэрэгцээнд анхаарч (жишээлбэл, видео уулзалт хийхээс илүү и-мэйл илгээх эсвэл утасны дуудлага хийх гэх мэт), мэдрэлийн эмгэгийн олон янз байдалд (жишээлбэл, дислекси, аутизм, диспракси) тохируулга хийх хэрэгтэй.

Ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудтай харилцах харилцаа нь хоёр талт байх бөгөөд харилцааны арга нь байнгын яриа хэлэлцээ, илүү албан ёсны зөвлөгөөн хийхэд дөхөм болох ёстой.

Харилцаа холбоо нь дараах тохиолдолд мөрдөх хүн хоорондын зай, эрүүл ахуй, шаардагдах зан үйлийн талаар тодорхой бөгөөд хамгийн сүүлийн үеийн зааварчилгааг агуулсан байна. Үүнд:

- a) ажлын байранд ирэхээсээ өмнө (жишээлбэл, утас, вэбсайт, дотоод сүлжээ, имэйлээр);
- b) ажлын байранд ирэхэд (жишээлбэл, тэмдэг, зурагт хуудас, дэлгэц, зарлал);
- c) ажлын байранд анх ороход(9.2 ба 12.2-ийг үзнэ үү);
- d) ажлын байран дээр (жишээлбэл, тэмдэг, зурагт хуудас, дэлгэц, зарлал).

Харилцаа холбоо нь бэлэн байгаа эсвэл байхгүй байгууламж, үйл ажиллагаа (жишээлбэл, цайны газар, хөргөгч, дундын тоног төхөөрөмж, анхны тусламж, хүний нөөц, мэдээллийн технологи)-ны талаар тодорхой зааварчилгаа өгнө.

9.1.3 COVID-19-тэй холбоотой үйл явц, удирдамж, эрсдэлийн түвшний өөрчлөлтийг тогтмол мэдээлэх шаардлагатай.

Байгууллага дараах арга хэмжээ авна. Үүнд:

- a) зочид, хүргэлтийн ажилтан, үйлчлүүлэгч болон бусад хүмүүст аюулгүй байдлын зааварчилгаа өгөх үүрэгтэй Ажилтныг томилох (энэ үүргийг гүйцэтгэх нэгээс илүү хүнийг сургаж, бэлтгэх);

- b) бүх ажилтан болон холбогдох сонирхогч талууд, түүний дотор гэрээт гүйцэтгэгч, агентлагийн ажилтанд харилцаа холбоог хүртээмжтэй, ашиглах боломжтой байлгах;
- c) зочин хүлээн авах үүрэгтэй, эсвэл хүргэлтийн ажилтан, үйлчлүүлэгч, олон нийттэй харилцдаг ажилтанд шаардлагатай сургалт зохион байгуулах;
- d) үйл ажиллагааны өөрчлөлт, аюулгүй байдлын арга хэмжээ, хяналтын талаар холбогдох мэдээллийг ханган нийлүүлэгч, үйлчлүүлэгч болон бусад холбогдох сонирхогч талуудад хүргэх;
- e) одоогийн харилцаа холбоог үр дүнтэй эсэхийг баталгаажуулахын тулд тогтмол хянаж, асуудал илэрвэл арга хэмжээ авах;
- f) ажлын байран дээр ялангуяа дуу чимээний түвшин өндөр ба бууруулах боломжгүй хэсэгт хүн хоорондын зайн шаардлагыг мөрдөх боломжийг бүрдүүлэх зорилгоор өдөр тутмын харилцааны үр дүнтэй механизмыг бий болгох.

9.2 Ажлын байранд анх ороход

Байгууллага нь ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудад ажлын байранд анх удаа орох, ажлын байрандаа буцаж ирэхийн өмнө COVID-19-ийн халдвар дамжуулах эрсдэлийг удирдахад шаардлагатай зан үйл, үйл явц, ажлын дадлыг олгоход чиглэсэн бүх боломжит арга хэмжээг авна.

Байгууллага 9.1-д зааснаас гадна дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) харилцаа холбоо, сургалтын материалыг боловсруулж, шаардлагатай бол сургалтад хамруулах (жишээлбэл, видео сургалт эсвэл цахим аргаар);
- b) ажилдаа ирэх, буцахдаа аюулгүй аялах талаар зөвлөгөө өгөх (жишээлбэл, боломжтой бол явган явах, дугуй унах, хувийн тээврийн хэрэгсэл ашиглахыг уриалах, мөн ажилтан нийтийн тээврээр үйлчлүүлэх шаардлагатай бол хүн хоорондын зай барих, маск, нүүрний хаалт хэрэглэх гэх мэт);
- c) ажлын ээлж эхлэх ба дуусах цагийн хуваарь, ажлын уян хатан цаг, ээлж эсвэл бусад өөрчлөгдсөн ажлын хэв маяг, хуваарийн талаар тодорхой зааварчилгаа өгөх;
- d) хүн хоорондын зай, эрүүл ахуй, ажлын ерөнхий аргын талаар зөвлөгөө өгөх;
- e) ажлын байранд нэвтрэх, ажил эхлэх, нийтийн эзэмшлийн талбай(жишээлбэл, цахилгаан шат, шат, бие засах газар, гал тогоо, коридор)ашиглах шинэ үйл явцыг мэдээлэх;
- f) зочид, үйлчлүүлэгч, үйлчилгээ авагч болон бусад хүмүүстэй аюулгүй харьцах зөвлөмж гаргах;
- g) онцгой байдлын журамд орсон өөрчлөлтийг мэдээлэх (4.7-г үзнэ үү).

9.3 Байнгын харилцаа холбоо

Байгууллага нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээ, хяналтыг бүх ажилтанд байнга сануулж, тэдгээрийг өөрчилсөн эсвэл аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлсэн тохиолдолд шинэчилсэн мэдээллээр тухай бүр хангаж ажиллана.

Байгууллага нь дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) ажилтан болон байгаа бол ажилтны төлөөлөлтэй байнгын харилцаатай байж, хөдөлмөрийн хэв маяг, ажлын зохион байгуулалт, ажлын байрны өөрчлөлтийн гэнэтийн үр дагаврыг ойлгуулах арга хэмжээ авах (4.4-ийг үзнэ үү);
- b) ажилтан, түүний дотор алсаас ажилладаг хүмүүстэй тогтмол харьцаж, биеийн, сэтгэцийн эрүүл мэнд, сайн сайхан байдлыг шалгаж, сэтгэцийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй асуудлын талаар тодорхой мэдээлэл өгөх (6-р хэсгийг үзнэ үү).

10 Эрүүл ахуй

10.1 Байгууллага нь бохирдсон гадаргуугаас COVID-19-ийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах, ажлын цагаар болон ажлын ээлж бүрийн төгсгөлд эрүүл ахуйн дэглэм сахих зорилгоор ажлын байраа цэвэр байлгах үйл явцыг хэрэгжүүлнэ.

Байгууллага нь COVID-19-ийн халдвар дамжих эрсдэлийг хязгаарлахын тулд гараа тогтмол, үр дүнтэй угаахын ач холбогдлыг ажилтанд ойлгуулсан байна. Байгууллага ажилтанд дараах зааврыг хүргэсэн байна. Үүнд:

- a) гараа 20 - 40 секундын турш цэвэр ус (халуун байвал илүү зохимжтой), савангаар угаах;
- b) гар угаах боломжгүй тохиолдолд гарыг COVID-19-ийн эсрэг аюулгүй, хэрэглэхэд үр дүнтэй, тохиромжтой гар ариутгагч бодисоор ариутгах (жишээлбэл, хамгийн багадаа 60% этанол эсвэл 70% изопропилийн спирт агуулсан);
- c) бохирдсон гарыг гар ариутгагч хэрэглэхийн өмнө боломжтой бол угаах.

Байгууллага нь зохих стандартын шаардлага хангасан гар ариутгагч бодис ашиглах нөхцөлийг бүрдүүлэх(жишээлбэл, шошго дээрх спиртийн төрөл, агууламжийг шалгах), зах зээл дээр хуурамч, чанар муутай, шаардлагад нийцэхгүй найрлагатай бүтээгдэхүүн байж болзошгүйг анхаарах хэрэгтэй.

10.2 Байгууллага дараах нөхцөлийг хангах зорилготой үйл явцыг хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) ажилтан гараа тогтмол угаахыг дэмжих (эсвэл боломжгүй бол халдваргүйжүүлэх), хэзээ угаах шаардлагатай болохыг зөвлөж байх (жишээлбэл, ажлын байранд орох, гарахаас өмнө, завсарлагааны өмнө ба дараа, дундын нөөц ажиллахын өмнө ба дараа, компьютер, багаж хэрэгсэл, ундаа зардаг машин, нийтийн эзэмшлийн талбайг ашиглахын өмнө ба дараа);
- b) ажилтан байгаа эсвэл дамжин өнгөрч буй газруудад гар угаах ба/эсвэл гар ариутгах нэмэлт төхөөрөмж бэлтгэх (жишээлбэл, орц, гарц, цахилгаан шатны ойролцоо, нийтийн эзэмшлийн талбай, үйлдвэрийн талбай);
- c) ажлын байр, тоног төхөөрөмжийг ялангуяа ажилтнаас ажилтан хооронд дамжуулахдаа байнга цэвэрлэх, халдваргүйтгэл хийх зорилгоор ажилтанд нэмэлт материал бэлэн байлгах;
- d) тогтмол хүрдэг гадаргууг байнга цэвэрлэх, халдваргүйтгэх (жишээлбэл хаалганы бариул, гэрлийн унтраалга, үйлчлүүлэгчийн цонх, төлбөр төлөх цэг, туршилтын гадаргуу, цахилгаан шат / урсдаг шатны товч, дундын нөөц);
- e) хэрэглэсэн нэг удаагийн ХХХ, нэг удаагийн маск, нүүрний хаалт зэрэг хог хаягдлыг тусад нь аюулгүй зайлуулах ба хог хаягдлыг үр дүнтэй, тохирсон байдлаар тогтмол зайлуулах.
- f) зурагт хуудас, самбар зэрэг хэрэгслээр дамжуулан ажилтанд гар угаах шаардлагатай арга техник, давтамж, нүүрэнд хүрэхээс зайлсхийх шаардлага, мөн нэг удаагийн цаасан алчуур эсвэл тохой руу ханиах, найтаах зэрэг эрүүл ахуйн зөв дадлыг сурталчлах;
- g) ариун цэврийн өрөөний агаар сэлгэлтийг нэмэгдүүлэх, цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг сайжруулах, тогтмол хийх, цаасан алчуур ашиглах нөхцөл бүрдүүлэх, хөдөлгөөнийг багасгах зорилгоор зохицуулалт хийх зэргээр ариун цэврийн өрөөг аюулгүй ашиглах (12.6.2-ыг үзнэ үү);
- h) шүршүүр, хувцас солих өрөөг аюулгүй ашиглах, боломжтой бол цөөн тооны ажилтанд зориулсан тусгай өрөө хуваарилах.

10.3 Байгууллага бохирдсон гадаргуугаас халдвар дамжих эрсдэлийг бууруулахын тулд тогтсон ажлын байр, талбай, ширээ ба/эсвэл тоног төхөөрөмж гэсэн зарчим баримталж,

ажилтан хувийн эд зүйлсээ шүүгээ, цүнх гэх мэт хувийн орон зайд хадгалах, ээлж бүрийн дараа ажлын байран дахь зүйлсээ авч явахыг шаардана.

Байгууллага нь ажлын байранд оруулсан эд зүйлс, байгууллагын тээврийн хэрэгсэл ашиглахтай холбоотой COVID-19-ийн халдвар дамжих эрсдэлийг бууруулах арга хэмжээ авах шаардлагатай. Байгууллага нь дараах арга хэмжээ авна. Үүнд:

- a) чухал ач холбогдолгүй хүргэлт, түүний дотор ажилтны хувийн хүргэлт хийхийг хязгаарлах;
- b) ажлын байранд орж ирсэн материал, тоног төхөөрөмж, бусад зүйлийг цэвэрлэх, ариутгах;
- c) ашиглалт бүрийн дараа дундаа ашигладаг тоног төхөөрөмжийн товчлуур/хүрдэг хэсгийг цэвэрлэх, ариутгах;
- d) үйл ажиллагаанд ашигладаг тээврийн хэрэгсэл, түүнчлэн ажлын автобусыг тогтмол цэвэрлэж, халдваргүйтгэх;
- e) хүргэлтийн ажилтны гар угаах давтамжийг нэмэгдүүлэх эсвэл боломжгүй бол гар ариутгагч бодисоор хангах.

11 Хувийн хамгаалах хэрэгсэл, маск, нүүрний хаалтыг ашиглах

11.1 ХХХ нь Ажилтныг ажлын байрны эрүүл мэнд, аюулгүй байдлын эрсдэлээс хамгаалдаг. COVID-19-ийн хувьд амьсгал дэмжих тоног төхөөрөмж, нүүрний хаалт (масктай хамт хэрэглэдэг) гэх мэт ХХХ ашиглаж болно. Ажилтан COVID-19-тэй холбоогүй эрсдэлээс хамгаалах зорилгоор ХХХ үргэлжлүүлэн ашиглаж болно.

Амны хаалт, нүүрний хаалт, түүний дотор гар хийцийн даавуун амны хаалт нь амьсгалах, ханиалгах, найтаах, ярих зэргээс агаарт ялгарсан дуслыг барих замаар COVID-19-ийн халдвар дамжихаас зарим талаар хамгаалдаг болохыг нотлох баримтууд нэмэгдэж байна. Нүүрний хаалтыг хүн хоорондын зай барих, гар угаах ба эрүүл ахуйн бусад арга хэмжээ (10-р зүйлийг үзнэ үү)-тэй хослуулан хэрэглэх нь COVID-19-тэй холбоотой эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга юм.

Мэргэжлийн ХХХ ба эмнэлгийн хэрэгсэл (жишээлбэл тоос шороо болон үйлдвэрийн агаарт ялгаруулах бусад аюулаас хамгаалах маск, амьсгалын аппарат гэх мэт)-ийг шаардлагатай хүмүүст, үйл ажиллагааг гүйцэтгэхэд зориулан хадгалсан байна.

11.2 Байгууллага нь дараах зорилгоор ХХХ, маск, нүүрний хаалтыг түр хугацаагаар авах шаардлагатай байж болзошгүй эсвэл ажилтан эсвэл бусад сонирхогч талуудын онцгой нөхцөл байдлыг харгалзан үзнэ. Үүнд:

- a) таних болон хамгаалалтын аюулгүй байдлын бусад зорилгоор маск, нүүрний хаалтыг түр хугацаагаар авах;
- b) уруулын хөдөлгөөнөөр ойлгодог сонсголын бэрхшээлтэй ажилтан болон бусад оролцогч талуудтай харилцах.

Хэрэв ХХХ, маск эсвэл нүүрний хаалтыг түр зуур авах шаардлагатай бол хүн хоорондын зай барих шаардлагатай. ХХХ, маск, нүүрний хаалт өмсөж, тайлахдаа дам бохирдлоос сэргийлэхийн тулд гараа угаах (эсвэл ариутгах) арга хэмжээ авах хэрэгтэй. Уруулын хөдөлгөөнөөр ойлгодог хүмүүс болон бусад оролцогч талуудын хоорондын харилцаа холбоог хөнгөвчлөхийн тулд байгууллага нь боломжтой бол зохих нүүрний тунгалаг хаалт ашиглах арга хэмжээ авсан байна.

11.3 Хэрэв COVID-19-тэй холбоотой эрсдэлийг удирдахад нэмэлт ХХХ, маск, нүүрний хаалт шаардлагатай бол байгууллага дараах арга хэмжээ авсан байна. Үүнд:

- a) ХХХ, маск, нүүрний хаалтыг хэзээ, хэрхэн яаж хэрэглэх зааврыг тогтоож, шаардлагатай бол сургалт явуулах;
- b) тохирсон ХХХ эсвэл маск үнэ төлбөргүй өгөх;

MNS ISO/PAS 45005 : 2021

- с) ХХХ ба маскыг зөв тоноглогдсон эсэхийг баталгаажуулж, ажилтанд хэрэглээ, ашиглалтын дараа аюулгүй хаях талаар зохих зааварчилгаа өгөх;
- д) ХХХ хэрэглэснээс үүдэлтэй ядаргааны улмаас аюулгүй ажиллагаа, тоног төхөөрөмжийн аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй тул Ажилтныг тогтмол хугацаанд завсарлага авч байхыг зөвлөх;
- е) бохирдсон, дахин ашиглах боломжтой ХХХ-ийг цэвэрлэх, ариутгах, угаах.

Ажилтан байгууллагын зүгээс санал болгосноос өөр нүүрний маск эсвэл нүүрний хаалт (жишээлбэл, гар хийцийн нүүрний хамгаалалт эсвэл байгууллагаас өгөөгүй бусад нүүрний хаалт) хэрэглэхээр сонгосон бол үүнийг байгууллагаас дэмжих хэрэгтэй.

ТАЙЛБАР: Тодорхой тохиолдолд үүнийг хууль тогтоомжийн болон бусад шаардлагаар хориглодог.

11.4 Байгууллага ажилтандаа дараах зүйлийг зөвлөж ажиллана. Үүнд:

- а) маск, нүүрний хаалт өмсөж, авахын өмнө гараа угаах, эсвэл гар ариутгагч хэрэглэх (боломжтой бол гар ариутгагч хэрэглэхийн өмнө бохирдсон эсвэл тостой гараа угаах);
- б) гараа тогтмол угаах, боломжгүй бол гараа ариутгах;
- с) бохирдлоос сэргийлэхийн тулд нүүр, нүүрний маск / хаалтад хүрэхгүй байх;
- д) хэрэв маск чийгтсэн эсвэл бохирдсон, бохирдсон байж болзошгүй гараар хүрсэн бол маск эсвэл нүүрний хаалтаа солих;
- е) маск эсвэл нүүрний хаалтыг хамгийн багадаа өдөрт нэг удаа (зарим төрлийн маск эсвэл нүүрний хаалтыг 4 цаг хэрэглэхийг зөвлөдөг), шаардлагатай бол хэд хэдэн удаа солих;
- ф) бусад гадаргууг бохирдуулахгүйн тулд маск, нүүрний хаалтыг битүүмжилсэн саванд хийж хадгалах, хаях;
- г) дахин ашиглах боломжтой маск эсвэл нүүрний хаалтыг угааж болдог материалаар хийсэн бол ашиглахын өмнө болон дараа өндөр температурт угаах;
- х) хэрэв маск эсвэл нүүрний хаалтыг угааж болохгүй материалаар хийсэн бол нэг удаа хэрэглэсний дараа аюулгүйгээр хаях;
- и) боломжийн хирээр хүн хоорондын зайн дүрмийг үргэлжлүүлэн дагаж мөрдөх.

12 Үйл ажиллагаа

12.1 Ерөнхий

Байгууллага нь 4-р зүйлд тодорхойлсон эрсдэлд чиглэсэн үйл явцыг бий болгох бөгөөд үүнд гэрээс ажиллах, хүн хоорондын зай барих болон ажлын байран дахь аюулгүй ажиллагааны бусад арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлэх талаар тусгасан байна.

Байгууллагын хэрэгжүүлсэн арга хэмжээ нь одоо байгаа хамгаалалтын аюулгүй байдалд сөргөөр нөлөөлж, эсвэл шинэ эрсдэл бий болгож байгаа эсэхийг үнэлэх ба эдгээр эрсдэлд чиглэсэн арга хэмжээ авна (Хавсралт А-г үзнэ үү).

Байгууллага нь хүмүүс чанга ярих хэрэгцээг багасгах зорилгоор ажлын байран дахь дуу чимээг багасгах боломжит арга хэмжээ (тухайлбал, хөгжмийн дуу багасгах, үс хатаагч гэх мэт төхөөрөмж ашиглах хугацааг багасгах) авна. Хашхирах, дуулах болон бусад төрлийн дуу хоолойн проекц гэх зэргээр чанга ярихад агаарт дусал дамжуулалтын зай нэмэгддэг. Боломжтой бол хүмүүс дуу чимээний түвшин намсгадаг маск, нүүрний хаалт хэрэглэдэг газар болон хүн хоорондын зай барих боломжгүй газар (жишээлбэл, үсчин, шивээсчин, физик эмчилгээний эмч зэрэг ойрын зайнаас үйлчилгээ үзүүлдэг эсвэл паб, ресторан гэх мэт олон нийтийн газар гэх мэт)-ын аль алинд нь дуу чимээг бууруулах нь чухал.

Хүн хоорондын зайн дүрмийг бүрэн дагаж мөрдөх боломжгүй үйл ажиллагаа, нөхцөл байдалд байгууллага 4.6-д заасан үйл ажиллагааг хэрэгжүүлж, үргэлжлэх цаг хугацааг аль болох богино байлгах хэрэгтэй.

Хэрэв аливаа үйл ажиллагаа нь хүн хоорондын зайн дүрмийг бүрэн дагаж мөрдөх боломжгүй ойрын зайнаас удаан хугацааны туршид ажиллах эсвэл ажилтан томилогдсон баг эсвэл хосоос өөр бусад хүмүүстэй холбоо тогтоох шаардлагатай бол тухайн үйл ажиллагаа аюулгүй явагдаж чадах эсэхийг байгууллага үнэлсэн байна.

Ажилтан аюулгүй орчинд ажиллах ёстой.

12.2 Ажлын байранд эргэж ирэх

Байгууллага нь бүх ажилтанд ажлын байранд анх эсвэл буцаж ирэхэд нь ажлын байр, ажиллах арга хэлбэрийн өөрчлөлтийг мэдээлэх үйл явцыг бий болгож, нөхцөл байдал өөрчлөгдөхөд үүнийг тогтмол хянаж, шинэчилж байна. Энэ нь ажилдаа буцаж ирэхээс өмнө өгсөн мэдээллээс гадна тодорхой үүрэг эсвэл үйл ажиллагааны зааварчилгааг багтаасан байна.

Байгууллага нь:

- a) ажлын байранд эргэж ирсэн, эсвэл өөр ажлын газар эсвэл сайтад байсан бүх ажилтанд бүрэн заавар, мэдээлэл өгөх;
- b) хэрэв ажилтны тоо буурсан бол үүнтэй холбоотой гарч болзошгүй аюулын талаар мэдээлэх;
- c) хүн хоорондын зайг барих зорилгоор ажлын байранд анх орох тухай зааварчилгааг авч буй ажилтны тоог хязгаарлах;
- d) аюулгүй, боломжтой бол ажлын байранд анх орох тухай зааварчилгааг гадаа, ил талбайд явуулах талаар анхаарах.

Байгууллага нь COVID-19 өвчний шинж тэмдгийн талаар мэдлэгийг дээшлүүлж, ажилтан болон бусад хүмүүс(жишээлбэл, зочид, үйлчлүүлэгч)-ийг ажлын байранд орохоос нь өмнө эрүүл мэндийн үзлэгт хамруулах зохих үйл явцыг бий болгох шаардлагатай. Үүнд эрүүл мэндийн байдлаа тайлагнах болон / эсвэл биеийн температурын шалгалтыг багтааж болно.

Зөвлөмж, зааварчилгааг хөдөлмөрийн эрүүл мэндийн мэргэжилтэн байгууллагын дотоод нөөцөө ашиглан эсвэл гадны үйлчилгээ, мэргэжлийн байгууллагуудтай зөвлөлдөх замаар өгөх боломжтой.

12.3 Ажлын байранд орох, гарах

Байгууллага нь ажлын байранд орох, ажлын байрнаас гарахад боломжийн хирээр аль болох хүн хоорондын зай барих болон гар угаах (эсвэл боломжгүй бол гар ариутгах) шаардлага тавьж ажиллана.

Байгууллага нь дараах арга хэмжээ авна. Үүнд:

- a) орох, гарах цэгүүд дээр хөдөлгөөний нягтралыг багасгах зорилгоор орох, гарах цагийг уян хатан болгох;
- b) боломжтой бол нэмэлт орох, гарах цэг бий болгох;
- c) боломжтой бол дугуйн тавиур гэх мэт нэмэлт зогсоол эсвэл байгууламж бий болгох;
- d) микроавтобус гэх мэт байгууллагын тээврийн хэрэгслээр зорчигчдын тоог хязгаарлах (суудал хоосон үлдээх);
- e) шал эсвэл ханан дээр хүн хоорондын зайн тэмдэг байрлуулах, боломжтой бол орох, гарах цэгүүдэд хөдөлгөөний нэг талын урсгалын системийг нэвтрүүлэх;
- f) өндөр эрсдэлтэй ажлын хэсэг эсвэл сайт (жишээлбэл, механик туршилтын талбай, химийн лаборатори)-д орох гарах тусгай цэгийг байгуулах;

MNS ISO/PAS 45005 : 2021

- g) товчлуур, биометрийн уншигч, цахим хаалга зэрэг мэдрэгчтэй аюулгүй байдлын төхөөрөмжийг тогтмол ариутгаж, нэвтрэх карт ба төхөөрөмжийн хооронд нь физик холбоо байх шаардлагагүй болохыг ойлгуулах;
- h) COVID-19-тэй холбоотой эрсдэлийг удирдах зорилгоор хэрэгжүүлж буй аюулгүй байдлын арга хэмжээ нь санамсаргүй байдлаар хамгаалалтын аюулгүй байдлын эрсдэлийг бий болгохгүй байхад анхаарах (Хавсралт А-г үзнэ үү);
- i) ажилтан, үйлчилгээ эрхлэгчдийн хувцас, цүнхийг хадгалах зориулалттай нэг хүнд зориулсан зай гаргах;
- j) ажилтан ажлын хувцас, тоног төхөөрөмжөө газар дээр нь солих, үлдээх нөхцөлийг бүрдүүлсэн өрөө, байр бэлдэх, энэ байранд хүн хоорондын зай барих боломж бүрдүүлэх;
- к) хувцас, тоног төхөөрөмжийг (жишээлбэл, дүрэмт хувцас, хатуу малгай, нүдний шил, бээлий) ажлын талбайд цэвэрлэх, ариутгах, угаах боломжтой байх.

12.4 Ажлын байрны орчимд ба хооронд шилжин явах

Байгууллага нь хүмүүс ажлын байран дундуур болон ажлын байрны хооронд шилжин явахдаа боломжтой бол хүн хоорондын зай барих үйл явцыг бий болгож, хэрэгжүүлнэ.

Энэхүү шилжилт, хөдөлгөөн аюулгүй байхын тулд байгууллага дараах арга хэмжээг авч үзэх хэрэгтэй. Үүнд:

- a) барилга байгууламж, талбай доторх хөдөлгөөнийг багасгах (жишээлбэл, тодорхой ажлын хэсэгт байх шаардлагатай ажилтны нэвтрэх эрхийг хязгаарлах, зөвшөөрсөн тохиолдолд радио, утас ашиглах дэмжих, дундаа хэрэглэсний дараа тогтмол цэвэрлэх);
- b) хяналттай нэвтрэх шаардлагатай газруудад контактгүй нэвтрэх (жишээлбэл, автоматжуулсан хаалга) хяналтыг бий болгох;
- c) гадаргуугийн бохирдлыг багасгах зорилгоор эрсдэл багатай хэсгүүдэд хүрэлцэж нэвтрэх (жишээлбэл, электрон хаалт, товчлуур) хяналтыг өөрчлөх;
- d) эрүүл мэндээ шалгуулж буй болон шалгаж буй ажилтан хоорондын шууд хавьтлыг тусгаарлах зорилгоор хаалт (жишээлбэл, эрүүл мэндийн үзлэг явуулж байгаа орох хэсэг, ажлын байрны хооронд болон бусад цэг) суурилуулах;
- e) ажлын хэсэг дээр нэг дор байх хүмүүсийн тоог багасгахын тулд баг/хос эсвэл цаг урьдчилан авах үйл явцыг ашиглах;
- f) барилга байгууламжид хөдөлгөөний нэг талын урсгалын системийг нэвтрүүлэх, хонгил, шат, явган зам, автомат хаалга г.м урт, нарийн хэсэгт анхаарах;
- g) явган шатаар явахыг зөвлөх, цахилгаан шат/урсдаг шатны хамгийн их багтаамжийг багасгах, гар ариутгагч тавих, байнга хүрэлцдэг (жишээлбэл, хашлага, товчлуур) хэсгүүдэд цэвэрлэгээ, халдваргүйтгэл тогтмол хийх;
- h) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс цахилгаан шат/урсдаг шатаар аюулгүй зорчих боломж олгох.

12.5 Ажлын бүс ба ажлын ширээ

Байгууллага нь боломжтой газруудад ажилтны ажлын бүс, ажлын ширээ хоорондын зай барих боломж бүрдүүлсэн байна.

Аюулгүй ажиллагааны дадлыг хэвшүүлэх зорилгоор байгууллага дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

- a) ажлын бүсийг шалгаж, боломжтой бол ширээ хоорондын зай барих үүднээс ажлын ширээг шилжүүлэх, ингэхдээ хэрэв бусад ажилтны хажуугаар өнгөрөх бол ажлын ширээндээ аюулгүй буцаж очиход шаардлагатай зайг анхаарах;
- b) ажилтнуудыг өөдөөс нь харуулж биш харин нуруугаар нь эсвэл зэрэгцээ эсвэл диагональ байхаар ажлын байруудыг зохион байгуулах;

- с) зарим ажлын ширээ ашиглахыг хориглох, эсвэл санал болгосон зайнаас бага зайд бэхэлсэн ажлын ширээнүүдэд тусгаарлах дэлгэц ашиглах;
- д) боломжтой бол ажилтан бүрд эсвэл боломжгүй тохиолдолд (жишээлбэл дуудлагын төв, сургалтын байгууламж) баг/хос бүрд ажлын байр, тоног төхөөрөмж хуваарилах, зайлшгүй шаардлагатай үйл ажиллагааны "сул ширээ" болон түргэн шуурхай ажиллах хэлбэрийг хязгаарлах;
- е) хүн хоорондын зайг шал эсвэл хананы тэмдгээр харуулах;
- ф) аль болох боломжийн хирээр хүн хоорондын зай мөрдөхийн тулд хаалт тавих, гэхдээ энэ нь аюулгүй бөгөөд ХАБЭА-н шинэ болон бусад эрсдэл үүсгэхгүй эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлэхгүй байхад анхаарах;
- г) хязгаарлагдмал орон зайд хүн хоорондын зай гаргах боломжийг олгохын тулд ажлын бүс дэх ажилтны тоог багасгах;
- h) байнга хүрдэг эд зүйлс, дундын тоног төхөөрөмжийн хэрэглээг хязгаарлаж, тогтмол цэвэрлэж, ариутгах.

12.6 Нийтийн эзэмшлийн талбайг ашиглах

12.6.1 Ерөнхий зүйл

12.6.1.1 Байгууллага нь зайлшгүй шаардлагатай нийтийн эзэмшлийн талбайг аюулгүй хэрэглэхэд чиглэсэн үйл явцыг хэрэгжүүлэх ба үүнд хамгийн багадаа дараах асуудлыг тусгасан байна. Үүнд:

- а) янз бүрийн бүлгийн хүмүүс ашигласны дараа цэвэрлэгээ, халдваргүйтгэл тогтмол хийх;
- б) нийтийн эзэмшлийн газар нэг дор байх хүмүүсийн тоог хязгаарлах;
- в) хүмүүсийн нийтийн эзэмшлийн газар байх хугацааг хязгаарлах;
- г) зай барих.

12.6.1.2 Байгууллага нь дараах асуудлыг зохих байдлаар авч үзнэ. Үүнд:

- а) бусад байгууллагатай байгууламж хамтран эзэмшдэг бол цахилгаан шат/урсдаг шат, хүлээн авах цэг, коридор, хамгаалалтын цэг гэх мэт нийтийн эзэмшлийн газруудад олны хөл хөдөлгөөн үүсгэхгүй байх зорилгоор ажилтан ирэх, гарах хугацааг зохицуулах;
- б) завсарлага авах цагийг зөрүүлж, гадаа орон зай илүү ашиглахыг дэмжих;
- с) боломжтой бол ажлын байрны гадаа зай, талбай ашиглахыг дэмжих;
- д) ажлын байрны бусад хэсэгт нийтийн эзэмшлийн орон зайг нэмэлтээр бий болгох;
- е) хүлээн авах эсвэл ижил төстэй хэсэгт ажилтан хамгаалах дэлгэц суурилуулах;
- ф) хоолны газар нээхээс зайлсхийж, ажилтныг өөрсдийн хоол хүнсээ авчрахыг уриалах, эсвэл зохих савласан хоолоор хангах;
- г) аяга, таваг, халбага зэрэг дундын нөөц ашиглахаас зайлсхийх, ажилтан бүр усны цорго, ундааны гоожуурыг ашигласны дараа цэвэрлэж, халдваргүйтгэж хэвших;
- h) хүн хоорондын зай барих дүрмийг баримтлах, нүүр тулсан харилцан үйлчлэлийг багасгах зорилгоор суудал, ширээг хөдөлгөх;
- i) ажлын цагаар ажилтан ажлын байранд байхыг зөвлөх (зориулалтын гаднах талбайг оруулаад), ажлын байрнаас гарах тохиолдолд хүн хоорондын зай барих дүрмийг дагаж мөрдөхийг шаардах;
- j) хувцас хадгалах эсвэл хувцас солих өрөө, шүршүүр болон бусад нийтлэг газруудын ашиглалтыг зохицуулах (жишээлбэл, хүүхэд, гэр бүлийн өрөө, мөргөлийн өрөө ба үүнтэй холбоотой хөл угаах байгууламж);

MNS ISO/PAS 45005 : 2021

к) ажлын цагаар хувцас хадгалах шүүгээ гэх мэт хувийн орон зайд хувийн эд зүйлс хадгалахыг дэмжих.

12.6.2 Ариун цэврийн өрөөний хэрэглээ

Байгууллага нь ажилтан болон бусад сонирхогч талууд, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан ариун цэврийн байгууламжийг аюулгүй ашиглахад чиглэсэн нэмэлт арга хэмжээг авч үзэх хэрэгтэй. Арга хэмжээнд дараах зүйлс орно. Үүнд:

- a) олон хүн нэг дор цуглахаас зайлсхийхийн тулд ариун цэврийн өрөөний ашиглалтыг зохицуулах;
- b) цэвэрлэгээ, халдваргүйтгэлийг өргөн хүрээнд хамруулж, давтамжийг нэмэгдүүлэх(ариун цэврийн өрөөний суудал, цоож, угаалтуур, бариул, өргөгч зэрэг хүрэлцдэг цэгүүдийг оруулан), хог хаягдлыг зайлуулах;
- c) хэрэв бие засах газрыг түр хугацаагаар хааж, сайтар цэвэрлэх тохиолдолд хэрэглэгчдийг хамгийн ойр байрлах бие засах газар руу чиглүүлэх тэмдэг тавих;
- d) ариун цэврийн өрөөний тасалгаа болон суултуур, шээлтүүрийн тоог хүн хоорондын зай барих зорилгоор хязгаарлах;
- e) усаа татахын өмнө жорлонгийн таг хаах тухай сануулсан тэмдэг ашиглах;
- f) хязгаарлагдмал орчинд биш, байгууламжийн гадна ариун цэврийн өрөөний дараалал үүсгэх системийг бий болгох;
- g) тусгай хэрэгцээтэй хэрэглэгчийг харгалзан, ажилтан эсвэл зочдыг ажлын байрны доторх тогтоосон нэг ариун цэврийн байгууламж ашиглахыг хүсэх;
- h) цаасан алчуураар хангах, цаасан алчуур байрлуулсан түвшинг хянах, хадгалах, хог хаягдлыг байнга аюулгүй хаях нөхцөлийг бүрдүүлэх;
- i) гар ажиллагаатай тоног төхөөрөмж гэхээсээ илүү автомат ба хөлөөр ажилладаг тоног төхөөрөмж ашиглах (жишээлбэл, автомат мэдрэгчтэй цорго, саван хуваарилагч, жорлонгийн ус татагч, хөлөөр ажилладаг хогийн сав)
- j) хяналтыг сайжруулах, нөхөн хангалт хийх(жишээлбэл, саван, ариутгагч, цаасан алчуур, жорлонгийн цаас)

12.7 Ажлын байран дээрх уулзалт, айлчлал

12.7.1 Байгууллага нь ажлын байранд уулзалт хийх, зочлох ажиллагааг хязгаарлаж, ялангуяа хязгаарлалтын үед гадаад болон дотоод биечилсэн уулзалтыг аль болох багасгах зорилгоор зайнаас ажиллах технологийг ашиглана.

12.7.2 Хэрэв нүүр тулан уулзах эсвэл ажлын байранд зочин зайлшгүй очих хэрэгтэй бол байгууллага нь эрүүл мэндийн үзлэг болон эрүүл мэндийн байдлаа мэдэгдэх зэргийг багтаасан ажлын байранд аюулгүй нэвтрэхэд шаардлагатай зан үйл, үйл явцыг урьдчилан мэдээлсэн байна.

Байгууллага нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) зөвхөн шаардлагатай зочдод нэвтрэх зөвшөөрөл олгох;
- b) зочдыг хаанаас ирсэн болон аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ авах шаардлагатай байгаа эсэхийг харгалзах;
- c) ажлын байранд нэг дор байх зочдын тоог хязгаарлах;
- d) тодорхой цагт зочлохыг хязгаарлах;
- e) боломжтой бол зочдод зориулсан тусдаа ариун цэврийн байгууламж гаргаж өгөх;

- f) хавьтлыг багасгахын тулд зайлшгүй шаардлагатай үйлчилгээ болон бусад гэрээт гүйцэтгэгчийн ажлын байранд ирэх хуваарийг шинэчлэх (жишээлбэл, ажилтан эсвэл үйлчлүүлэгчтэй хавьтлыг багасгахын тулд ажлын бус цагаар);
- g) хавьтлыг илрүүлэхийн тулд зочдын мэдээллийг бүртгэх (жишээлбэл, нэр, огноо, уулзалтыг зохион байгуулж байгаа ажилтны нэр, зочинтой ажлын байран дээр эсвэл үйл ажиллагааны явцад ойрын эсвэл урт хугацаанд хавьталд орсон хүний нэр), тухайн мэдээллийг аюулгүй хадгалах, тодорхой хугацааны дараа (14 хоногоос багагүй эсвэл албан ёсны удирдамжид заасан хугацааны дагуу) устгалд оруулах талаар баталгаа өгөх;
- h) зочны дэлгэрэнгүй мэдээллийг хэрхэн бүртгэх, ажлын байранд хэрхэн нэвтрүүлэх болон хэрхэн үдэж гаргах журамд өөрчлөлт оруулах (жишээлбэл, олон хүн дамжуулж нэг үзэг ашиглахаас сэргийлж хүлээн авагч өөрийн үзгээр мэдээллийг бүртгэх, нэвтрэх болон гарахдаа өөр гарц ашиглах, нэг удаагийн зочдын үнэмлэх ашиглах);
- i) зочдыг хүн хоорондын зай барих дүрэм болон бусад аюулгүй байдлын арга хэмжээг мөрдөхийг шаардах;
- j) нэвтрэх эрхтэй, уулзалтад оролцох хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан тусгай зохицуулалт хийгдсэн эсэхийг баталгаажуулах.

12.7.3 Хэрэв биечлэн уулзалт зохион байгуулах шаардлагатай байгаа бол байгууллага нь дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

- a) уулзалтад оролцох шаардлагатай хүний тоог хамгийн бага байхаар зохицуулах мөн хүн хоорондын зай барих дүрмийг хэрэгжүүлэх;
- b) дамжуулж ашиглах зүйлсээс зайлсхийх (жишээлбэл, үзэг, ус болон кофены аяга);
- c) хурлын өрөөнд гар ариутгагч бодис байрлуулах;
- d) боломжтой бол уулзалтыг гадаа орчинд эсвэл агааржуулалт сайтай өрөөнд зохион байгуулах;
- e) хүн хоорондын зай барих тэмдэглэгээг хана болон шалан дээр байршуулах.

12.8 Олон нийттэй ажиллах

Ажлын байрны гадна, дотор орчинд олон нийттэй (үйлчлүүлэгч, хэрэглэгч болон бусад хүмүүс) шууд харьцдаг ажилтан халдвар тараах эсвэл халдвар авах эрсдэлийг бууруулах болон хүн хоорондын зай барих дүрмийг хэрэгжүүлэхийн тулд байгууллага нь хяналт тавих шаардлагатай.

Байгууллага нь дараах арга хэмжээг авна. Үүнд:

- a) олон нийттэй шууд тулж ажилладаг ажилтныг олон нийт болон тусгай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй хэрхэн аюулгүй байдлыг ханган харилцах талаар сургах (7-р зүйлийг үзнэ үү);
- b) олон нийтэд аюулгүй байдлын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, хяналт ба хүн хоорондын зай барих талаар зурагт хуудас, самбар, мэйл илгээх болон бусад харилцаа холбооны хэрэгсэл ашиглан мэдээлэх;
- c) хүн хоорондын зай барих, аюулгүй байдлын бусад арга хэмжээнүүдийг дагаж мөрдөхийг олон нийтэд сануулах зорилгоор тогтмол мэдэгдэл хийх;
- d) барилга байгууламжийн дотор эсвэл хязгаарлагдмал гадна орчинд нэг дор байх нийгмийн гишүүдийн тоог хязгаарлаж, хүн хоорондын зайг хадгалах;
- e) гадаа дараалал үүсгэхдээ аюулгүй орчин ашиглах, боломжтой бол хана болон шалан дээр хүн хоорондын зай барих тэмдэглэгээ байрлуулах, дарааллыг аюулгүй байдлын нэмэлт аюул үүсгэхгүй, хамгаалалтын аюулгүй байдлын нэмэлт эрсдэл учруулдаг тул гадна орчны тохижилтод өөрчлөлт оруулахгүйгээр зохион байгуулах (А хавсралтыг үзнэ үү);

MNS ISO/PAS 45005 : 2021

- f) халдвар дамжих эрсдэлтэй барилга байгууламж, гадна талбайн орц, гарц, гаднах бусад хэсгүүдэд гар ариутгагч бодис байрлуулах;
- g) маск эсвэл нүүрний хаалт зайлшгүй хэрэглэх шаардлагатай газар хяналт тавих;
- h) үйлчлүүлэгч, түнш эсвэл үйлчилгээ авч буй хүн болон бусад нийгмийн гишүүд өөрийн гэсэн маск, нүүрний хаалтгүй эсвэл эдгээр нь тохиромжгүй бол нэг удаагийн маск олгох асуудлыг авч үзэх;
- i) хүний гар байнга хүрдэг газар болон дамжуулж ашигладаг зүйлсийг тогтмол ариутгах, халдваргүйтгэхэд анхаарах (жишээлбэл, банкны карт, бэлэн мөнгөний машины товчлуур, дэлгүүрийн лангуу, сагс болон тэргэнцрийн бариул, эмчилгээний ор эсвэл сандал, чийрэгжүүлэх төвийн тоног төхөөрөмж);
- j) бүтээгдэхүүнд хүрэхийг хязгаарлах (жишээлбэл, үзүүлэнгийн янз бүрийн арга ашиглах, тэмдэг, бүтээгдэхүүнийг сольж тавих);
- k) ажилтан ба нийгмийн гишүүдийн хооронд байнгын харилцаа явагддаг газруудад (жишээлбэл, төлбөрийн цэгүүдэд, хэрэглэгчийн үйлчлүүлэх ширээнд) шилэн хаалт гэх мэт хаалт байршуулах;
- l) хүн хоорондын зай барих арга хэмжээг мөрдөх боломжгүй чухал шаардлагатай биш нийтийн газруудыг багасгах (жишээлбэл, дэлгүүрийн хувцас өмсөж үзэх өрөө);
- m) хэрэглэгч эсвэл үйлчилгээ авагчтай ойрын зайнаас харьцах хугацааг хязгаарлах, шаардлагатай бол нөхцөл байдалтай уялдуулж шинэчлэх (жишээлбэл, үсчин болон гоо сайхны үйлчилгээ үзүүлэх хугацааг багасгах, хоол, хүнс болон уух зүйлс захиалахдаа электрон төхөөрөмж ашиглах; хэрэглэгч ачаагаа машиндаа зөөхөд туслах нэг биш хоёр ажилтан гаргаж өгөх);
- n) дугаарлахад хүн хоорондын зай барих тэмдэглэгээ байршуулсан, хөл хөдөлгөөнд ихтэй орц гарц дээр сургагдсан зохицуулах ажилтантай, сайтар цэвэрлэгээ хийгддэг, хаягдал зайлуулж, нөхөн хангалтыг тогтмол хийдэг бие засах газрын байгууламжаар хангах;
- o) хоорондоо мөнгө солилцохгүй төлбөр, буцаан олголтын шийдлийг дэмжих;
- p) хавьтал үүсгэдэггүй цуглуулах, буцааж өгөх цэг байгуулах;
- q) цуглуулах цагийг зөрүүлэх;
- r) шаардлагатай бол захиалгын системийг бий болгох (жишээлбэл, ресторан, гоо сайхны үйлчилгээ, шивээсний газар, биеийн тамирын заал).

12.9 Томилолтоор ажиллах

12.9.1 Байгууллага нь ажилтай холбоотой шаардлагагүй бүх томилолтоос зайлсхийж, хүргэлт хийх, хүлээн авах зэрэг зайлшгүй шаардлагаар ажилтныг томилохдоо аюулгүй байдлыг хангах хяналтыг хэрэгжүүлнэ.

Хэрэв ажилтай холбоотой томилолтоор явах шаардлагатай бол байгууллага дараах арга хэмжээг авах шаардлагатай. Үүнд:

- a) аяллын явцад шаардлагатай чиглэлийн янз бүрийн хувилбар, ажилтан дамжин өнгөрөх шаардлагатай газар (жишээлбэл, төмөр замын буудал, нисэх онгоцны буудал, зочид буудал)-ыг харгалзан үзэх;
- b) аяллын төрөл бүрийн байгууллагын өөр өөр шаардлагыг харгалзан үзэх (жишээлбэл, агаарын тээврийн компани эсвэл гатлага онгоцны үйлчилгээний хязгаарлалт, нисэх онгоцны буудал эсвэл боомтын тодорхой шаардлага);
- c) оргил цагийн үед нийтийн тээвэрт ачаалал үүсгэхгүйн тулд зорчих цагийн уян хатан байдлыг дэмжих;

- d) боломжтой бол хүмүүсийг унадаг дугуй, цахилгаан унадаг дугуй эсвэл скутер эсвэл хувийн тээврийн хэрэгсэл ашиглахыг дэмжих;
- e) зайлшгүй шаардлагатай байгууламжийн байршлыг тодорхойлж (жишээлбэл, бие засах газар, хоол хүнс болон уух зүйл), аюулгүй ажиллагааны талаар зааварчилгаа өгөх;
- f) ажилтан хоногоор гэрээсээ хол байх шаардлагатай бол төвлөрсөн бүртгэл хийж, шөнө байрлах байр нь хүн хоорондын зайн шаардлага, эрүүл ахуйн заавартай нийцэж байгаа эсэхийг баталгаажуулах.

12.9.2 Нийтийн тээврийн хэрэгслээс бусад автомашинаар явах бол байгууллага нь:

- a) аль ч тээврийн хэрэгсэл ашигласан нэг дор хамтдаа зорчих хүмүүсийн тоог багасгах;
- b) томилолтоор явах тогтсон баг эсвэл хос бий болгох;
- c) боломжтой бол моторт тээврийн хэрэгслийн агаарын солилцоог нэмэгдүүлэхийн тулд цонхыг онгойлгох;
- d) ээлж солигдох хооронд болон бусад ажилтан ашиглахаас өмнө тээврийн хэрэгслийг цэвэрлэж, ариутгасан эсэхийг баталгаажуулах;
- e) ажилтан өөд өөдөөсөө харан суухаас зайлсхийхийг шаардах;
- f) тээврийн хэрэгсэлд, тэр дундаа таксинд нэгээс олон хүн сууж байвал маск эсвэл нүүрний хаалт хэрэглэхийг зөвлөх.

12.10 Хүргэлт

Байгууллага нь хүргэлтийг (захидал, илгээмжийг шуудангаар хүргэх ажлыг багтаасан) аюулгүй, найдвартай хүргэх эсвэл хүлээн авах арга хэмжээг авсан байна.

Байгууллага нь:

- a) хүргэлтийн үеэр түүнчлэн төлбөр төлөх, баримт бичгийг солилцох зэрэгт хүнтэй тулж харьцах харьцааг багасгах (жишээлбэл, төлбөр хийх, гарын үсэг зурах, баримт бичиг солилцох цахим хэрэгсэл);
- b) гэрт нь эсвэл байгууллагын хяналтад байдаггүй өөр газарт хүргэлт хийж буй ажилтанд аюулгүй харьцах, түгээх талаар зааварчилгаа өгөх;
- c) ачих, буулгах цэгийг хянах (жишээлбэл, зай барих тэмдэглэгээ бүхий бүс, үйлчлүүлэгч болон бусад ажлын хэсгүүдэд хавьтал үүсгэхгүйгээр ачааг буулгах);
- d) ирж буй илгээмжийн давтамжийг багасгах (жишээлбэл, янз бүрийн сайт руу нийлүүлэх гадны хангамжийн үйлчилгээнээс зайлсхийх зорилгоор худалдан авалтын төвлөрсөн үйл явцыг бий болгох, нэг дор их хэмжээгээр захиалах);
- e) тээврийн хэрэгслээс ачаа ачих, буулгахад нэг ажилтан эсвэл тогтсон хосоор ажиллах;
- f) хүргэлтийн жолооч нарт халамжийн байгууламж руу (жишээлбэл, бие засах газар) хяналттай, аюулгүй нэвтрэх боломж олгох;
- g) хэрэв аюулгүй ажиллагааны дадлыг зөрчихгүй гэж үзвэл жолооч нарыг тээврийн хэрэгсэлдээ үлдэхийг зөвлөх;
- h) дахин ашиглах боломжтой хүргэлтийн хайрцаг, ачих хэрэгсэл гэх мэтийг тогтмол цэвэрлэж, ариутгах;
- i) хүргэсэн ачааг цэвэрлэх эсвэл халдваргүйтгэх, эсвэл халдваргүйтгэх боломжгүй зүйлийг тусгаарлаж, гадаргуу дээрх COVID-19 вирусын байгалийн задрал явагдах боломж олгохын тулд янз бүрийн материалын албан ёсны зааварчилгааг мөрдөх.

MNS ISO/PAS 45005 : 2021

13 Гүйцэтгэлийн үнэлгээ

13.1 Мониторинг ба үнэлгээ

13.1.1 Байгууллага нь дараах асуудлаар мониторинг ба үнэлгээг тогтмол байдлаар хийнэ. Үүнд:

- a) аюулгүй ажиллагааны арга хэмжээ болон хяналт нь ажилтныг хэр үр дүнтэй хамгаалж байгаа;
- b) ажил хэрхэн явагдаж байгаа;
- c) ажлын байран дахь аюулгүй ажиллагааны арга хэмжээг мөрдөх байдал;
- d) ажилтны дундах халдварын түвшин;
- e) ажилдаа ирээгүй ажилтны түвшин болон түүний ажиллаж байгаа бусад ажилтанд үзүүлэх нөлөө;
- f) нийгмийн дундах эрсдэлийн түвшний өөрчлөлт эсвэл бусад гадаад асуудал (4.1-ийг үзнэ үү).

13.1.2 Мониторинг ба үнэлгээний үр дүнг дараах асуудлыг авч үзэхэд хэрэглэнэ. Үүнд:

- a) зааварчилгааг хэрхэн мөрдөж байгааг тодорхойлох;
- b) эрсдэлийг тасралтгүй үнэлэх үйл явц явагдаж байгаа эсэх, үр дүнтэй ажиллаж байгаа эсэхийг тодорхойлох;
- c) хяналтын арга хэмжээний тохиромжтой байдлыг тодорхойлох, шаардлагатай бол тэдгээрийг өөрчлөх, сайжруулах, илүү идэвхтэй хэрэгжүүлэх;
- d) хяналтын арга хэмжээ нь шийдвэрлэх шаардлагатай шинэ эрсдэлийг (ямар ч төрлийн) үүсгэж байгаа эсэхийг тодорхойлох;
- e) ажилтан ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөл болон бусад сонирхогч талуудын санал хүсэлтийг харгалзан үзэх (жишээлбэл, хэрэглэгч, үйлчлүүлэгч).

Байгууллага нь аюулгүй байдлын арга хэмжээг мөрдөхийн тулд үйл ажиллагааны нэмэлт хяналтыг хэрэгжүүлэх талаар авч үзнэ.

13.2 Удирдлагын дүн шинжилгээ, осол ба тэдгээрийг мэдээлэх

13.2.1 Ерөнхий зүйл

Байгууллага нь мониторинг, үнэлгээний үр дүнг (13.1-ийг үзнэ үү) тодорхой хугацаанд хянах бөгөөд дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

- a) аюулгүй ажиллагааны хэм хэмжээ, хяналтыг дагаж мөрдөх түвшинд тодорхойлсон асуудал;
- b) ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудын мэдээлсэн осол;
- c) ослын үндсэн шалтгаан (үүд);
- d) ослыг арилгахад чиглэсэн үйл ажиллагааны үр нөлөө, үүнд, осол тохиолдох үед авсан арга хэмжээ болон ослын үндсэн шалтгааныг арилгах арга хэмжээ зэрэг орно.

Удирдлагын дүн шинжилгээний үр дүнг зохих ёсоор ажилтан болон бусад холбогдох сонирхогч талуудад мэдээлнэ. Харилцаа холбоо нь хэрэгжүүлсэн, нэвтрүүлэх гэж байгаа болон сайжруулах бусад арга хэмжээг багтаасан байна (14-р зүйлийг үзнэ үү).

13.2.2 Гадны сонирхогч талуудад мэдээлэх

Хэрэв ажилтан ажлын шугамаар COVID-19 халдвар авсан тохиолдолд холбогдох зохицуулах байгууллага болон эрүүд мэндийн байгууллагад мэдэгдэнэ.

Тайлбар 1: Үүнийг тухайн орон нутгийн, бүс нутгийн ба үндэсний хэмжээний зааварчилгаагаар шаардаж болно.

Байгууллага нь нөхцөл байдал өөрчлөлттэй уялдан мэдээлэх шаардлага өөрчлөгдөж болохыг мэдэх шаардлагатай. Байгууллага нь мэдээлэх шаардлагыг тогтмол хянаж, мэдээллийг шинэчилж байна.

Тайлан шаардлагатай эсэхийг шийдэхдээ байгууллага нь тухайн өвчтөн нийгмийн ерөнхий нөлөөлөл гэхээсээ илүүтэй ажлын нөхцөлөөс үүдэж халдвар авсан байж болзошгүй талаар үндэслэлтэй нотолгоо байгаа эсэхийг тодорхойлох ёстой.

Ажилтан COVID-19-ийн халдвар авсан нь ажлын нөхцөлөөс үүдсэн эсэхийг тодорхойлоход анхаарах хүчин зүйлүүдэд дараах зүйлс орно. Үүнд:

- a) хөдөлмөрийн үйл ажиллагааны шинж чанар эсвэл ажлын зохион байгуулалт нь ажилтны өртөх эрсдэлийг нэмэгдүүлсэн бол;
- b) өртөх эрсдэлийг нэмэгдүүлэхэд хүргэсэн онцгой, тодорхой осол;
- c) хэрэв хөдөлмөрийн үйл ажиллагаа нь ажилтныг мэдэгдэж буй коронавирусын аюулд шууд, хяналт тавих үр дүнтэй арга хэмжээ авалгүйгээр өртүүлсэн бол (жишээлбэл, хүн хоорондын за барих, ХХХ).

Хэрэв нэгээс илүү ажилтан COVID-19 халдвар авсан бол (ажлын нөхцөлөөс болсон эсэхээс үл хамааран) байгууллага нь холбогдох зохицуулах байгууллага болон эрүүл мэндийн байгууллагад мэдээлнэ. Ингэснээр цаашид байгууллага болон олон нийтийн дунд COVID-19 өвчин өргөн хүрээтэй тархахаас сэргийлэх арга хэмжээг авч үзэж, хэрэгжүүлэх боломжтой болох юм.

Тайлбар 2: Үүнийг тухайн орон нутгийн, бүс нутгийн ба үндэсний хэмжээний зааварчилгаагаар шаардаж болно.

14 Сайжруулалт

Байгууллага нь COVID-19-тэй холбоотой эрсдэлийн хяналтаа сайжруулах боломжийг тодорхойлж, шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. Үүнд, COVID-19 илэрсэн тохиолдлын нөхцөл байдал, өвчний талаарх шинэ мэдээлэл, халдварын хяналт, эмчилгээний талаар байнга шинэ мэдээлэлтэй байх зэрэг орно.

Байгууллага нь мониторинг, үнэлгээ болон удирдлагын дүн шинжилгээний үр дүнг харгалзан үзэж, дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ (13-р зүйлийг үзнэ үү). Үүнд:

- a) аюулгүй байдлын арга хэмжээ, хяналтыг сайжруулах эсвэл өөрчлөх талаар яаралтай арга хэмжээ авах;
- b) шинээр нэвтрүүлсэн арга хэмжээний хамгаалалтын аюулгүй байдлын үр дагаврыг харгалзан шаардлагатай бол аюулгүй байдлын нэмэлт арга хэмжээ, хяналтыг хэрэгжүүлэх;
- c) ажилтны хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж болох орон нутгийн, бүс нутгийн эсвэл үндэсний эрсдэлийн түвшин, албан ёсны зааварчилгаа эсвэл хууль эрх зүйн шаардлагад орсон өөрчлөлт гэх мэт гадаад, дотоод нөхцөл байдалд гарсан өөрчлөлтөд чиглэсэн арга хэмжээ авах (4.1-ийг үзнэ үү);
- d) мониторинг, үнэлгээ болон удирдлагын дүн шинжилгээнд ажилтан, байгаа бол ажилтны төлөөллийн оролцоо, зөвлөгөөг дэмжиж ажиллах, тэдний дэвшүүлсэн асуудлыг шийдвэрлэх мөн асуудлуудыг шийдвэрлэх.

Байгууллага нь COVID-19-тэй холбоотой эрсдэлийг үргэлжлүүлэн хянаж байхын тулд нөхцөл байдлын өөрчлөлттэй шинж чанарыг харгалзан энэхүү баримт бичигт тусгагдсан зааварчилгааг тогтмол хянаж, сайжруулж байх хэрэгтэй.

**А хавсралт
(мэдээллийн)
Хамгаалалтын аюулгүй байдлын асуудал**

А.1 Ерөнхий

Энэхүү хавсралт нь, тухайн байгууллагын хамгаалалтын аюулгүй байдлын менежер болон COVID-19-өөс хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүрэгтэй бүх хүмүүст хамаарна.

COVID-19-ийн эрүүл мэндэд учруулах эрсдэл нь өнөөгийн нэн тэргүүнд тавих асуудал боловч терроризмын болон хорлон сүйтгэгчдийн үйл ажиллагааны аюул занал (жишээлбэл, үндэсний аюулгүй байдалд заналхийлэх) чухал хэвээр байна. Энэ нь байгууллага үйл ажиллагаандаа тохируулга хийхдээ эдгээр аюул заналхийллийг тооцох, аюулгүй байдлын арга хэмжээг байнгын идэвхтэй байлгаж бусад өөрчлөлтөд нэмэлтээр ашиглах эсвэл дэмжлэг болгон ашиглах шаардлагатай. Эдгээр арга хэмжээг санамсаргүй орхигдуулах эсвэл хэрэгжүүлээгүй тохиолдолд байгууллагын болон хувь хүний аюулд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг.

Байгууллага COVID-19-ийн хариу арга хэмжээг төлөвлөх болон хэрэгжүүлэх үед хамгаалалтын аюулгүй байдлыг тусгаагүйн улмаас үйл ажиллагааны өөрчлөлттэй холбоотой урьдчилж таамаглаагүй үр дагавар нь эрсдэлийг бий болгодог.

Энэхүү хавсралт нь хамгаалалтын аюулгүй байдлын ач холбогдлыг тайлбарлаж, байгууллага үр дүнтэй хамгаалалтын аюулгүй байдлыг хадгалахын зэрэгцээ COVID-19 цар тахлаас шалтгаалсан (зай барих г.м) өөрчлөлтийг хэрхэн хэрэгжүүлэх зөвлөмж өгнө. Үүнд хамгаалалтын аюулгүй байдлыг бууруулах үр дүнтэй арга хэмжээг авч үзэх, хэрэгжүүлэхэд байгууллагад туслах хамгаалалтын аюулгүй байдлын холбогдох зөвлөмжийн холбоосууд багтсан.

А.2 Үйл ажиллагаа ба дадал

COVID-19-тэй холбоотой арга хэмжээ эсвэл хяналтыг хэрэгжүүлэхдээ хамгаалалтын аюулгүй байдлын хэвийн үйл ажиллагаа, дадлыг харгалзан үзэх хэрэгтэй.

Байгууллага дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- a) санал болгож буй аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэхдээ, хамгаалалтын хэлтэстэй (хэрвээ байдаг бол) зөвлөлдөх, оролцуулах;
- b) хамгаалалтын ажилтантай зөвлөлдөх, хамтран ажилладаг байгууллагын болон барилга байгууламж хамтран ашигладаг байгууллагын хамгаалалтын арга хэмжээг харгалзан үзэх;
- c) эрсдэлийн үнэлгээг шинэчлэх бүх үйл явцад хамгаалалтын аюулгүй байдлыг харгалзан үзэх;
- d) COVID-19-ийн эрсдэлийг удирдах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтан, хамгаалалтын аюулгүй байдлын үүрэг бүхий ажилтантай зөвлөлдөх, мөн хоорондын үүрэг, хариуцлагыг зохицуулах, тодруулах.

А.3 Хэрэгжүүлэх арга хэмжээнүүд

Аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийгээгүй нөхцөлд хамгаалалтын аюулгүй байдлын арга хэмжээг цуцалж, өөрчилж, багасгаж болохгүй. Шаардлагатай тохиолдолд, байгууллага холбогдох хамгаалалтын аюулгүй байдлын мэргэжилтнээс (жишээлбэл, үндэсний аюулгүй байдлын байгууллага эсвэл цагдаагийн терроризмтой тэмцэх мэргэжилтэн) зөвлөгөө авах хэрэгтэй.

Байгууллага нь хамгаалалтын аюулгүй байдалд шууд чиглэгдээгүй боловч аюулгүй байдлыг хангах үр дүнтэй арга хэмжээг харгалзан үзэх ёстой (жишээлбэл, гудамжны ямар нэгэн биетийг эсвэл тавилгыг зайлуулах нь дараалалд явж буй болон зогсож буй явган зорчигчийг “тээврийн хэрэгсэл бүхий” зэвсэгт халдлагад илүү өртөмтгий болгох боломжтой).

Байгууллага дараах асуудалд анхаарна. Үүнд:

- a) хамгаалалтын аюулгүй байдлын ажилтнууд зөвхөн өөрийн үүрэгт анхаарлаа төвлөрүүлэх;
- b) COVID-19-ийн аюулгүй байдлын арга хэмжээг хэрэгжүүлэхэд хяналт эсвэл бусад үйл ажиллагаанд (жишээлбэл, дарааллыг зохицуулах) нэмэлт ажилтны хэрэгцээ бий болсон тохиолдолд нэмэлт нөөцөөр хангах;
- c) хамгаалалтын аюулгүй байдлын ажилтнууд ажил үүргээ гүйцэтгэхэд аюулгүй гэдэгтээ итгэлтэй байх, шаардлагатай хэрэгсэл, байгууламж, төхөөрөмжөөр хангах (жишээлбэл, зохих шаардлагад нийцсэн нэвтрэх эрхтэй байх ХХХ болон гар угаах өрөө байр);
- d) хувийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг эрсдэлд оруулалгүйгээр аюулгүй байдлын үүргээ хэрхэн гүйцэтгэх зааварчилгаа өгөх (жишээлбэл, хүмүүсийг таньж бүртгэх зорилгоор маск болон нүүрний хаалтыг авах шаардлага тавих үед зай барих талаарх удирдамж);
- e) хамгаалалтын ажилтнууд тулгамдаж буй асуудлаа тавих аргыг тохиролцох.

**В хавсралт
(мэдээллийн)
Хүртээмж, оролцооны тухай асуудал**

В.1 Ерөнхий ойлголт

Энэхүү хавсралт нь байгууллагын COVID-19-ийн аюулгүй байдлын арга хэмжээ хэрэгжүүлэх үүрэг бүхий бүх ажилтанд хамаарна.

COVID-19-ийн ажилтай холбоотой эрсдэлийг удирдах нэмэлт арга хэмжээг хэрэгжүүлэх нь эсрэгээрээ хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Энэхүү хавсралтад байгууллагын COVID-19-той холбоотой арга хэмжээ нь хүмүүсийг орхигдуулах эсвэл төлөвлөөгүй нэмэлт эрсдэлийг бий болгохоос сэргийлэх зорилгоор цаашид анхаарах зүйлсийг авч үзнэ.

В.2 Хувь хүний хэрэгцээтэй холбоотой анхаарах зүйлс

Байгууллага нь, хувь хүний хэрэгцээг ойлгохын тулд ажилтан ба хэрэв байгаа бол ажилтны төлөөлөлтэй ярилцах мөн тэдний оролцоо, зөвлөгөөг дэмжиж ажиллана. Байгууллага нь дараах асуудлыг анхаарах шаардлагатай. Үүнд:

- a) хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс COVID-19-т эмзэг байдаггүй;
- b) зарим хүмүүсийн COVID-19-т эмзэг байдал нь нүдэнд ил харагддаггүй (жишээлбэл, чихрийн шижин, амьсгалын замын өвчин, зүрхний эмгэг);
- c) зарим хүмүүсийн хөгжлийн бэрхшээлийг харах боломжгүй байдаг бөгөөд хувь хүний хэрэгцээнд нийцсэн тусгай тохируулга хийх шаардлагатай байж болно.

Эдгээр зааварчилгаанд дурдсан ерөнхий арга хэмжээнүүдээс гадна, байгууллага нь эрүүл мэнд, аюулгүй байдал, сайн сайхан байдал, хувийн нөхцөл байдал, сүүлийн үеийн болон одоо байгаа асуудлуудыг ойлгохын тулд бүх ажилтны дунд судалгаа хийж болно.

В.3 Харгалзан үзэх хүчин зүйлс

Байгууллага нь дараах зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- a) ажлын байрны гадна орчинд нөлөөлөх дараах хүчин зүйлс:

- 1) хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зориулсан зогсоолын одоо байгаа байгууламжийг хадгалах, эдгээрийг багасгахгүй байх (жишээлбэл, дараалалд байгаа үйлчлүүлэгчид нэмэлт зай бий болгох зорилгоор);
- 2) COVID-19-оор өвчлөх өндөр эрсдэлтэй (эсвэл эрүүл мэндийн суурь асуудалтай) хүмүүст зориулсан аюулгүй "буух" бүсийг бий болгох;
- 3) ажлын байрны эргэн тойронд нэг чиглэлтэй эсвэл салаалсан шинэ маршрут үүсгэх үед тэргэнцэр болон хөдөлгөөн дэмжих бусад нэмэлт хэрэгсэл бүхий хэрэглэгчид хангалттай зай гаргах (үүнд зай барих шаардлагыг харгалзан үзэх);
- 4) шинэ зам нь налуу замгүй бол өөр чиглэл санал болгох;
- 5) замын хашлагыг авах эсвэл дугуйн нэмэлт зогсоол бий болгох ажлыг хийж байгаа үед өөрчлөлтийг мэдэрч болох анхааруулах гадаргуу тавих;

- b) ажлын байрны дотор орчинд нөлөөлөх дараах хүчин зүйлс:

- 1) хүн бүрд хүртээмжтэй гар ариутгагч төхөөрөмж байлгах (жишээлбэл, өндрийг харгалзан үзэх);
- 2) нэг-чиглэлийн зам буюу систем нь явах замын уртыг нэмэгдүүлдэг бөгөөд энэ нь хөдөлгөөний бэрхшээлтэй хүмүүст нөлөөлөхийг харгалзан үзэх (жишээлбэл, нэмэлт амралтын цэг шаардлагатай байж болно);
- 3) барилга байгууламж дотор нэг чиглэлтэй эсвэл салаалсан шинэ маршрут үүсгэх үед тэргэнцэр болон хөдөлгөөн дэмжих бусад нэмэлт хэрэгсэл бүхий хэрэглэгчид хангалттай зай гаргах (үүнд зай барих шаардлагыг харгалзан үзэх);

- 4) Асран хамгаалагч, туслах ажилтан шаардагдах ажилтанд зэргэлдээ ажлын байр эсвэл ширээ захиалах боломжийг олгох;
 - 5) COVID-19-ийн халдвар авах өндөр эрсдэл бүхий эсвэл COVID-19-оор хүндээр өвчлөх эрсдэлтэй гэж үзсэн хүмүүст зориулсан хүртээмжтэй ариун цэврийн байгууламжийг байрлуулах, эрүүл ахуйн стандартыг тогтмол хангах үүднээс цэвэрлэгээ, ариутгал хийх давтамжийг нэмэгдүүлэх;
 - 6) COVID-19-ийн халдвар авах өндөр эрсдэл бүхий эсвэл COVID-19-оор хүндээр өвчлөх эрсдэлтэй гэж үзсэн хүмүүсийг хамтарч ажиллах боломж олгох ба ингэхдээ хүн хоорондын зайн болон эрүүл ахуйн өндөр түвшинг хангах, бусад хүмүүстэй харилцах харилцааг хязгаарлах;
- с) харилцаа холбоонд анхаарах дараах хүчин зүйлс:
- 1) хараагүй, харааны эсвэл сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн харилцааны хэрэгцээ;
 - 2) ойлгомжтой, тогтвортой, энгийн хэллэг ба танигдсан тэмдэг бүхий хангалттай том тэмдэг, мэдэгдэл;
 - 3) видео бичлэгт хадмал орчуулга ашиглах;
 - 4) ажилтан болон бусад холбогдох хүмүүс ажлын байранд нэвтрэхээс өмнө ашиглах, нэвтрэх боломжтой ажлын байранд орсон өөрчлөлтийг харуулсан видео бичлэг хийх, ажлын байранд зааварчилгаа өгөх асуудлыг харгалзан үзэх;
 - 5) маск ба нүүрний хаалт нь уруулын хөдөлгөөнөөр ойлгох, нүүрний хувирлаар дамжуулан сэтгэл хөдлөлийг мэдрэх хэрэгцээ шаардлагатай хүмүүст харилцааны асуудал үүсгэдэг тул боломжтой бол нэмэлт арга хэмжээ авах (жишээлбэл, тунгалаг нүүрний бүрхүүл ашиглан хүн хоорондын зай барих нь нүүрний маск болон хаалтгүйгээр шууд харилцах боломж олгох);
 - 6) Вэбсайтуудын вэб контентын хүртээмжтэй байдлын зааварчилгаа буюу (Web Content Accessibility Guidelines - WCAG)⁸-г ядаж 2-р түвшинд (тохиромжтой түвшин 3) хангах.

Ном зүй

[1] ISO 10075-1, Ergonomic principles related to mental workload — Part 1: General issues and concepts, terms and definitions

[2] ISO 10075-2, Ergonomic principles related to mental workload — Part 2: Design principles

[3] ISO 10075-3, Ergonomic principles related to mental workload — Part 3: Principles and requirements concerning methods for measuring and assessing mental workload

[4] ISO 15384:2018, Protective clothing for firefighters — Laboratory test methods and performance requirements for wildland firefighting clothing

[5] ISO 45001:2018, Occupational health and safety management systems — Requirements with guidance for use

[6] ISO 45003:², Occupational health and safety management — Psychological health and safety at work — Guidelines for managing psychosocial risks

[7] CWA 17553:2020, Community face coverings — Guide to minimum requirements, methods of testing and use

[8] W3C Web Accessibility Initiative (WAI). Web Content Accessibility Guidelines (WCAG). WAI [online]. Available from: [https:// www .w3 .org/ WAI/ standards -guidelines/ wcag/](https://www.w3.org/WAI/standards-guidelines/wcag/)

[9] World Health Organization (WHO), 24 February 2010. Diseases: Emergencies preparedness, response. Available from: [https:// www .who .int/ csr/ disease/ swineflu/ frequently _asked _questions/ pandemic/ en/](https://www.who.int/csr/disease/swineflu/frequently_asked_questions/pandemic/en/)

[10] World Health Organization (WHO), 2020. Health topics/Coronavirus. Available from: [https:// www .who .int/ health -topics/ coronavirus #tab = tab _1](https://www.who.int/health-topics/coronavirus#tab=tab_1)

[11] International Labour Organization (ILO), Prevention and Mitigation of COVID-19 at Work. Available from: [https:// www .ilo .org/ wcm5p5/ groups/ public/ - - -ed _protect/ - - -protrav/ - - -safework/ documents/ instructionalmaterial/ wcms _741813 .pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/-/-ed_protect/-/-protrav/-/-safework/documents/instructionalmaterial/wcms_741813.pdf)

[12] International Labour Organization (ILO), Managing work-related psychosocial risks during the COVID-19 Pandemic. Available from: [https:// www .ilo .org/ wcm5p5/ groups/ public/ - - -ed _protect/ - - -protrav/ - - -safework/ documents/ instructionalmaterial/ wcms _748638 .pdf](https://www.ilo.org/wcmsp5/groups/public/-/-ed_protect/-/-protrav/-/-safework/documents/instructionalmaterial/wcms_748638.pdf)

²ISO/DIS 45003:2020 хэвлэлтийн үе шатанд байгаа.